

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ



СУДАЛГААНЫ ТӨСӨЛТ АЖЛЫН НЭР: МОНГОЛЧУУДЫН ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СУДАЛГААНЫ БАГИЙН УДИРДАГЧ:

С.Түвшинзаяа

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:

Ц.Булган
Ц.Гэрэл
Б.Дэлгэрсайхан
Г.Нарантунгалаг
А.Одгэрэл

СУДАЛГААНЫ ТӨСӨЛТ АЖЛЫН ТӨРӨЛ:

Бие даасан судалгаа

УЛААНБААТАР, 2015

ХУРААНГУЙ:

Монголчуудын үндэсний үнэт зүйлийн судалгааг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар нарийвчлан судлах нь нийгмийн салбарт судалгааны ажил хийж буй олон судлаачдын хувьд чухал ач холбогдолтой ажил болох юм. Өнөөдөр бид олон төрлийн шилжилтийн нөлөөгөөр үндэсний үнэт зүйлсийн тогтолцоонд ямар өөрчлөлт гарч байгааг мэдэхгүй, нарийвчлан судлаагүй явсаар байна. Бизнесийн нийтлэг хүрээндээ бид олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулах болсон бөгөөд cross-cultural төрлийн судалгааг хийх хэрэгцээ шаардлага ч үүнийг дагаад бий болж байна.

Иймээс бид судалгааны төслийн баг байгуулж Value survey module 2013 Hofstede аргачлалаар хийж нийтдээ 4214 хүний түүвэртэйгээр тодорхойлж гаргалаа. Асуулга судалгаанаас гадна экспертүүдийн ярилцлага болон түүхэн баримт бичгүүдэд тулгуурлан дүгнэлт хийхийг оролдсон юм.

Монголчуудын үнэт зүйлийн 6 хэмжүүрийг тооцож гаргахад гэр бүлийн хүрээнд хамтач боловч ажлын орчинд илүү бодгальч шинжтэй, маскулин байдал феминин байдлаас илүү давамгайлсан, урт хугацааны хандлага бага, тодорхойгүй зүйлээс зугтах түвшин бага, эрх мэдлийн ялгаа заагийг хүлээн зөвшөөрөх хандлага ялимгүй өндөр, баригдмалаас илүү чөлөөт нь давамгайлсан болох нь тодорхойлогдсон юм.

ОРШИЛ

Үндэсний соёл нь түүхэн үзэгдэл тул Монголын газар нутаг дээрх нэн эртний цаг хугацааны соёлоос эх авч, өнөөгийн нарийн бүтэц бүхий цогц соёл болох хүртлээ олон мянган жилийг туулжээ. Монголчууд XVI зуунд дорнын соёлын нөлөөнд, XX зууны эхээр өрнийн соёлын нөлөөнд орсон хэдий ч язгуурын болон уламжлалт соёлоо хадгалсаар байгаа нь энэхүү соёлыг судлах, хэмжих, нөлөөллийг олох зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Түүнчлэн Монголын нийгэм 1990 онд социалист нийгмээс ардчилсан нийгэм рүү хөрвөн орохдоо нийгмийн оюун санаа, улс төр, эрх зүй, эдийн засаг, гадаад харилцааны хүрээнд ихээхэн өөрчлөлттэй тулгарсан бөгөөд одоо ч энэ өөрчлөлт, шилжилтийн үе бүрэн дуусаагүй байгаа тул завсрын үе хэмээгдэж байна. Энэ үеийн Монголын нийгмийн оюун санааны амьдрал ихээхэн тодорхой бус, алаг цоог, зөрчил ихтэй байна. Иймээс энэ шилжилтийн үе дэх Монголчуудын үнэт зүйлийг тодорхойлох нь олон судалгааны анхдагч өгөгдлийг бий болгохын зэрэгцээ цаашид хэрхэх талаар таамаглах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Монголчууд бидний эдийн засаг, бизнесийн нийтлэг хүрээндээ олон улсын хамтын ажиллагааг ихээр хөгжүүлж байгаа бөгөөд эдгээр хамтын ажиллагаанд соёлын нөлөөллийг авч үзэх нь зайлшгүй юм. Иймээс бид олон улсад хийгдсэн соёл хоорондын харьцуулалт хийх боломж бүхий судалгааны аргачлалуудыг харьцуулан судласны үндсэн дээр Geert Hofstede-ийн аргачлалыг ашиглан судалгаа хийх шаардлагатай гэж үзсэн юм.

Үндэсний үнэт зүйлийн судалгаа нь нийгмийн салбарын бүхий л судлаачдын хувьд судалгааны ажлын үндсэн суурь болох нь гарцаагүй юм. Нэн тэргүүнд СЭЗДС-ийн бизнесийн менежментийн ухааны докторын болон мастериин судалгааны ажлуудад үндсэн суурь болж ашиглагдахаас гадна Нийгмийн маркетингийн төвийн хэрэгжүүлэх төслүүдэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Тус судалгааны ажлын багийн үндсэн бүрэлдэхүүнд СЭЗДС-ийн тухайн чиглэлд суурилсан судалгааны ажлын чиглэл бүхий 2 удирдах ажилтан, 3 тэнхмийн 4 багш нар багтаж байгаа юм. Бид цаашид байгууллагын соёл, уур амьсгал, ёс зүйн уур амьсгал, ажилтнуудын зохисгүй зан төлөв, нийгмийн маркетинг, нийгмийн хариуцлага зэрэг чиглэлүүдээр илүү нарийвчилсан судалгааны чиглэлээ тодорхойлон ажиллаж байгаа болно. Мөн тус багт бакалавр, магистр, докторын түвшинд суралцагчидыг хамруулсан болно.

СУДАЛГААНЫ АСУУДАЛ:

Монголын нийгэм 1990 онд социалист нийгмээс ардчилсан нийгэм рүү хөрвөн орохдоо нийгмийн оюун санаа, улс төр, эрх зүй, эдийн засаг, гадаад харилцааны хүрээнд ихээхэн өөрчлөлттэй тулгарсан бөгөөд одоо ч энэ өөрчлөлт, шилжилтийн үе бүрэн дуусаагүй байгаа тул завсрын үе хэмээгдэж, нийгмийн оюун санааны амьдрал ихээхэн тодорхой бус, алаг цоог, зөрчил ихтэй (ФСЭХ, 2014) байна. Мэдлэг ухааны олон салбараар нягтлан хэлэлцэж, сая хариулбаас зохих олон асуулт монголын шинжлэх ухаан, ялангуяа нийгэм, хүмүүнлэгийн ухааны судалгаа, сургалт, практикийн өмнө шинэ шинэ хэрэгцээ буй болсныг нотолж, ерөнхийлөн өгүүлбээс монгол хүмүний тухай мэдлэггүйгээр монголын нийгмийн аливаа асуудлыг зохион байгуулах, шийдвэрлэх, ерөөс монгол хүн өөрийгөө “мэдэхгүйгээр” амьдрах, аж төрөх бололцоогүй нь тодорхой болов (Цогтсайхан, 2015) гэж үзэж болохуйц юм.

Ийм тодорхой бус байгаагийн шалтгааныг ихэвчлэн суурин соёлттой холбон тайлбарлах нь бий. Олон мянган жил газар нутгийн тогтоц, цаг уурын нөхцөл байдал, байгаль орчны онцлогоос шалтгаалан нүүдэллэн аж төрж байсан уг ард түмэн ХХ зууны эхэн үед л суурин соёлын нөлөөнд орсон гэвэл хэт өрөөсгөл болох биз. Харин ч олон зуун жил нүүдэл, суурин соёлыг авах гээхийн ухаанаар хослуулж, хоршуулж явсан хэрнээ өнөө үед яагаад өөрийгөө танихаа больтлоо эргэлзэж буйг өөрийн гэх үнэт зүйл тодорхойгүй байгаатай холбоотой гэж үзэж болохуйц байна. Үндэсний гэх үнэт зүйл тодорхойгүй байгаа зарим шалтгааныг дурдвал:

1. Соёлын хэт хожимдол (cultural lag):

Хөгжил дэвшлийг хангахдаа материаллаг болон материаллаг бус соёлыг аль алиныг төлөвшүүлэх хэрэгтэй байдаг. Гэтэл бодит байдал дээр материаллаг тал түрүүлж өөрчлөгдөж, материаллаг бус зүйлс хоцорч үлддэг. Үүнийг соёлын чиглэлээр судалгаа хийдэг судлаачид соёлын хожимдол (cultural lag) хэмээн тодорхойлдог байна. Иймээс өөрчлөлтийн нөлөөгөөр үүсч буй сөрөг үзэгдлүүдийг материаллаг бус соёлоор дамжуулан зөв зохистой удирдах нь зүйн хэрэг юм.

Монголчууд бид сүүлчийн удаа нийгэм эдийн засгийн тогтолцооны томоохон өөрчлөлтийг 1990-ээд оноос эхлүүлсэн бөгөөд энэ нь улс төрийн ардчилал, чөлөөт эдийн засгийн тогтолцоо юм. Ардчилсан үндсэн хууль, ардчилсан сонгууль, ардчилалын үнэт зүйл бүрийг бид тогтолцоондоо шингээн өөрчлөлт хөгжлийг хангах оролдлого хийсээр 20 гаруй жилийг ардаа орхилоо. Бидэнд хөгжил дэвшил нүдэнд харагдахуйц бий болж байгааг хүлээн зөвшөөрч байгаа ч энэ нь зөвхөн өнгөн тал буюу материаллаг соёл төдий. Харин бидний сэтгэлгээ, үзэл бодол, итгэл үнэмшил, ёс суртахуун, үзэл суртал өнөөдөр яг хаана байгаа вэ? Ардчилалын үнэт зүйлс бидний үйл хөдлөлд бүрэн тусгалаа олж байна уу? гэсэн асуултуудад хангалттай гэсэн хариулт харамсалтай нь олддохгүй байна.

Түүнчлэн хөгжсөн улс орнуудын амжилттай хэрэгжсэн тогтолцоо, туршлагыг бид эдийн засаг, бизнесийн нийтлэг хүрээндээ нэвтрүүлэхээр оролдож, туршлага сургамжуудыг бий болгосоор явна. “Швед” “Британи”, “Америк”, “Япон”, “Швейцарь”, “Австрали”, “Солонгос” гэсэн тодотголтой олон систем, тэргүүн туршлагуудыг улс орны хэмжээнд болон салбар,

байгууллагуудын түвшинд нэвтрүүлэх гэж оролдож байна. Хэдий тийм боловч түүнийг дагаж хүмүүсийн үйл хөдлөлийг зөв тогтоож чадахгүйн улмаас гарз, хохирол, сөрөг үйлдлүүдийг дагуулсаар байна.

Өнөөдөр бид өндөр хөгжилтэй орнуудын хэрэглээнд байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрсдийн хэрэглээнд өндөр хурдаар нэвтрүүлж, технологийн дэвшлүүдийг ч ашиглаж улс орны нийт эдийн засаг ч өсч хөгжиж байна. Гэхдээ үүнийг дагаж эдийг шүтэх хандлага, зохисгүй хэрэглээ, буруу хэвшил, гэмт хэрэг, зөвхөн баяжих эрмэлзлийг эрхэмлэх, төрийн дээд удирдлагад ёс суртахуунгүй хүмүүс шурган орох, авилгал, хулгай дээрэм дэлгэрэх зэрэг гаж үзэгдлүүд нүүрлэжээ. Энэ мэтчилэн Монголын нийгмийн оюун санааны амьдрал ихээхэн тодорхой бус, алаг цоог, зөрчил ихтэй байгаагаас харахад өөрчлөлт зөвхөн хожимдож буй хэрэг биш, “соёлын хэт хожимдол” гэж хэлж болохоор түвшинд хүрчээ. Энэ нь манай улсын хөгжилд чөдөр тушаа болж, чөтгөрийн тойргийн эхлэл болсон хамгийн чухал шийдвэрлэх асуудал юм.

2. Соёлын түрэмгийлэл (cultural imperialism):

Зөвхөн монголчууд төдийгүй дэлхий даяараа нэн эртнээс суурьшихаас илүү нүүдэллэж (монголчуудын гэх нүүдлээс гадна яригдах бүх хөдөлгөөнт амьдралыг хамааруулав), амьдралын төлөө бядан явсан нь саяхан. Гэтэл одоо нүүдэлчид гэж нэрлэхээр хуруунд багтах цөөн угсаатан үлджээ. Яагаад? ХХ зууны эхэн үед гадны эрдэмтэн, судлаачид, аялагчид Монголчуудын ирээдүйн талаарх цөөн хэдэн бошиг буулгаж байсны нэг нь Бельгийн католик шашны лам Леон Ван Дайкийн суурин соёлд идэгдэж дуусна гэсэн зөгнөл байв. Суурин соёл өөрийн давуу талаараа бусад соёлоо уусгах бөгөөд дэлхий дээр өнөөг хүртэл суурин соёлоос зугтсан ард түмэн гэж үгүй. Эрдэмтэн Л.Түдэв “Энэ бүхэнд зохицох ганц арга зам нь нүүдэл, суурин 2 иргэншлийг зүй зохистой хослуулсан нөхцөл байдлыг бүрдүүлэх төрийн үзэл баримтлал бий болгож, урт удаан хугацаанд цогцолбор хэрэгжүүлэх бодлого юм. Өөрөөр хэлбэл хоймсон соёл иргэншлийн (бицивилизация) бодлогыг монголын хүн бүрийн дотор ухаанд бойжуулж, буйлуулах хэрэгтэй юм” (Түдэв, 2010) гэж дүгнэжээ.

3. Бие хүний үнэт зүйлийн тодорхойгүй байдал:

Үндэсний соёл нь үнэт зүйлийн системээс бүрдэн бий болох бөгөөд тодорхой нэгэн нийгэм, бүлгийн хувьд нийтлэг байхын хамт бие хүний хандлагыг тодорхойлдог (Hofstede G. , 2001) учир бие хүний үнэт зүйл, үндэсний үнэт зүйл нь харилцан бие биенээ бүрэлдүүлэгч шинжтэй. Иймээс бидний дотоод үнэт зүйлийн зөрчил нь нийгмийн системийн тодорхойгүй байдлын эх үүсвэр болдог байна.

Монголчуудын үнэт зүйлсийн дараах 6 хэмжүүрээр хэмжихэд ямар түвшинд байгааг тодорхойлох нь судалгааны үндсэн асуулт юм. Үнэт зүйлийн хэмжүүр тус бүрийг тодорхойлбол дараах байдалтай байна.

- Power distance index - Монголчуудын эрх мэдлийн ялгааг хүлээн зөвшөөрөх байдал ямар вэ?

- Masculinity and femininity- Монголчууд амжилт ололтонд илүү хандаж байна уу эсвэл амьдралын чанарт илүү хандаж байна уу?
- Individualism vs Collectivism - Монголчууд хамтач уу эсвэл бие даасан уу?
- Long-term orientation - Монголчууд урт хугацаанд ханддаг уу, богино хугацааны хандлагатай юу? Өнөөдрөөрөө амьдарч байна уу, ирээдүйд хандсан хандлага их байна уу?
- Uncertainly avoidance- Монголд яагаад хууль дүрэм журам зохицуулалтуудын хэрэгжилт хангалтгүй байдаг вэ? Тодорхойгүй нөхцөл байдлаас зайлсхийх хандлага хэр байна вэ?
- Indulgence vs Restraint- Чөлөөт үү баригдмал уу– хүсэл тэмүүлэл, найз нөхөд, зугаа цэнгэл, секс, хэрэглээ зэрэгт хэт их хандаж байна уу, эсвэл өөрийгөө хязгаарлах, болгоомжтой хандах хандлагатай байна уу?

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ:

Глобал соёлын хүрээнд судалгаа явуулдаг нэрт эрдэмтэн Geert Hofstede-ийн гаргасан үндэсний үнэт зүйлсийн 6 хэмжүүрийг VSM 2013 нэгдсэн аргачлалын дагуу Монгол үндэсний үнэт зүйлийг судлах хангалттай түүвэрт судалгаа хийх замаар тодорхойлж гаргахад энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Зорилтууд

- ✓ Үндэсний үнэт зүйлсийн тухай онолын судалгаа хийж, түүнийг хэмжих Hofstede –ийн аргачлалыг нарийвчлан судалж, эзэмших
- ✓ Судалгааны дизайн боловсруулах, тестлэх
- ✓ Монголын үндэсний үнэт зүйлийг судлахад хангалттай түүвэрлэлтийн төлөвлөгөө хийж, түүний дагуу өгөгдөл цуглуулах
- ✓ Өгөгдлийн шинжилгээ хийж үндэсний соёлын 6 хэмжүүрийг тооцох
- ✓ Үнэт зүйлийн хэмжүүр тус бүрээр нийгмийн салбарын гадаад дотоодын нэрт эрдэмтэн судлаачдыг оролцуулсан хэлэлцүүлэх хийх болон монголын судлаачдын гаргасан түүхэн баримт бичиг, бүтээлүүдэд судалгаа хийж дүгнэлт гаргах
- ✓ Судалгааны өгүүлэл, нийтлэлүүдийг бичиж, нийтийн хүртээл болгох, эрдэм шинжилгээний ажлын санд оруулах зэрэг зорилтыг тавин ажилласан болно.

ОНОЛЫН СУДАЛГАА

Үнэт зүйл гэж юу вэ?

Үнэт зүйл буюу Value гэдгийг судлаачид дараах байдлаар тодорхойлсон байна.

- Үнэт зүйл-итгэл үнэмшил
- Үнэт зүйл -хүсч буй зорилгоор илэрхийлэгдэн, ямарваа нэг үйлдлийг хийх сэдэл болж өгдөг
- Үнэт зүйл -стандарт болон шалгуурууд болдог
- Үнэт зүйл -аливаа үйлдэлд хөтөлж чиглүүлдэг чухал хамаарал
- Үнэт зүйл -олон төрлийн хандлага зан төлвийн шалтгаан, нөлөөлөл
- Үнэт зүйл-чухал байдлын, /ач холбогдлын/ дэс дараалал

Тухайн үндэстнээс өөр хэн ч санаа зовдоггүй, зөвхөн үндэстэн өөрөө л санаа тавьдаг асуудлын нэг бол үндэстний соёл буюу үнэт зүйлийн тогтолцоо нь юм. Улс орнуудад гадаадын туслалцаа дэмжлэгийн олон шижим, чиглэлүүд байдаг ч үндэстний үнэт зүйлд нь санаа тавьж, энэ талаар төсөл хөтөлбөр тэр бүр хэрэгжүүлээд байдаггүйг анзаарсан биз. Тэгвэл үнэт зүйл гэж юуг ойлгох вэ? Хүн судлаач эрдэмтэн Kluckhorn үнэт зүйл гэдэг нь хувь хүний онцлог чанар болон бүлгийн өвөрмөц шинж чанарыг илэрхийлэх илэрхий болон илэрхий бус ойлголт бөгөөд боломжит хэв шинж, арга барил, үйл ажиллагааны үр дүнгээс сонголт хийхэд нөлөөлдөг хүсүүштэй байдлын тухай ойлголт (Hofstede, 2001) гэж тодорхойлжээ. Rokeach (1972)-ийн тодорхойлолтод тухайн хүнийг үнэ цэнт зүйлтэй гэж уг хүн өөр хэв маяг, оршин байх зорилгоос илүүд үзсэн тогтвортой үйл ажиллагааны хэв маяг, оршин байх зорилготой байхыг хэлнэ гэжээ.

Үнэт зүйл нь хандлага, чухалчлан үзэх, үзэл бодол зэрэг ухагдахуунтай зарим талаар адил шинжийг агуулдаг учир тодорхойлоход төвөгтэй байдаг ажээ. Олон судалгаа шинжилгээний ажилд хандлага болон үнэт зүйл нь өөр өөр ухагдахуун болохыг дурдсан байдаг. Тэгвэл, хандлага нь тодорхой нэгэн зүйл эсвэл нөхцөл байдлаас шалтгаалан бий болох итгэл үнэмшлүүдийг хэлэх бол үнэт зүйл нь ямар ч тохиолдолд өөрчлөгдөшгүй тогтсон, бие хүний хувьд болон нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшлүүдийн цогц (McGuire, Garavan, Saha, & O'Donnell, 2006) юм. Мөн итгэл үнэмшил нь үнэт зүйлтэй маш ойр хэрэглэгддэг бөгөөд ихэнх тохиолдолд бие биеэс нь салгахын аргагүй ойлголт байдаг. Иймээс үнэт зүйл нэн тэргүүнд авч үздэг, чухалчилдаг, хүсүүштэй байдлын тухайд тогтсон итгэл үнэмшил юм.

Орчин үеийн бизнесийн практикт харагддаг үйлчлүүлэгчиддээ анхаарал тавих, гологдол гаргахгүй байх, мөнгө буцаан олгох баталгаа гаргах зэрэг нь үнэт зүйлийн суурьгүйгээр байх боломжгүй юм. Бид өдөр тутмын амьдралдаа үнэнч шударга байдал, эрх чөлөө, аюулгүй байдал, хувийн нууц зэрэг ойлголтыг, нийгэм-соёлын хүрээнд харилцаа, итгэл найдвар, итгэл бишрэл, энэрэл нигүүлсэл, хүндлэл зэрэг ойлголтыг их хэрэглэдэг. Ажлын хүрээнд үр ашиг, бүтээмж, үнэнч шударга байдал, уян хатан байдал, ололт амжилт, үнэнч байдал, дэг журам зэрэг ойлголтыг хэрэглэдэг нь энгийнээр бүгд бидний үнэт зүйлийг илэрхийлж байна. Эдуард Спрангер бие хүнд институцийн, нийгмийн, улс төрийн, онолын, итгэл бишрэлийн, гоозүйн, эдийн засгийн үнэт зүйлд суурилсан өөрийн гэсэн үнэт зүйлийн бүрдэл байдаг (Erdagon & Ali, 2013) гэж үзжээ. Үүнийг бид үнэт

зүйлийн систем гэж нэрлэдэг. Хүн бүр төдийгүй байгууллага ч үйл ажиллагаагаа үнэт зүйлд суурилан явуулдаг байна.

Үнэт зүйл нь хоёр туйлын хооронд илэрхийлэгдэх мэдрэмж юм. Үнэт зүйл нь дараах зүйлстэй холбогдоно. Үүнд: нүгэл ба буян, бохир ба цэвэр, аюултай ба аюулгүй, даруу биш ба даруу, муухай ба сайхан, хэвийн биш ба хэвийн, гажуу ба логиктой, ёс суртахуунлаг ба ёс суртахуунлаг бус гэх мэт.

Бидний үнэт зүйл амьдралын явцад маань эрт тогтдог бөгөөд үнэт зүйл нь ухамсарт бус байдалтай (хэдийгээр бид өөрсдийнхөө үнэт зүйлийг субъектив байдлаар төгс ухамсарлаж болох боловч) байдаг. Бидний үнэт зүйл нь хоорондоо холбоотой бөгөөд ихэнх хүмүүс нэгэн зэрэг хэд хэдэн зөрчилдөөнт үнэт зүйлтэй байдаг тухайлбал, “эрх чөлөө”, “тэгш эрх” гэх мэт. **Бидний дотоод үнэт зүйлийн зөрчил нь нийгмийн системийн тодорхойгүй байдлын эх үүсвэр болдог.** Бидний амьдралын нэг хүрээнд болсон үйл явдал нуугдмал үнэт зүйлийг идэвхжүүлж, энэ нь бидний амьдралын өөр нэг хүрээн дэх үйл хөдлөлд маань нөлөөлдөг. Нөхцөл байдлын тухай бидний ойлгоц өөрчлөгдөх нь үнэт зүйлийн тухайд дотоод зөрчлийг тэнцвэржүүлдэг. Тухайлбал нөхцөл байдлыг бид “таатай” гэж үзэх эсвэл “асуудалтай” гэж үзэх эсэх гэх мэт.

Бид хэрэв “үнэт зүйлтэй” бол энэ нь бидэнд тодорхой хэмжээгээр хамаатай асуудал байгаад, гарц үр дүн нь нэгнийх нь хувьд “сайн”, нөгөөгийнх нь хувьд “тааруу” гэж бид тодорхойлж болно. Тухайлбал, “мөнгөтэй байх” тухайд авч үзвэл “их байх” нь сайн, “бага байх” нь тааруу гэж үзэх нийгэм байхад зарим сүсэгтний хувьд мөнгөтэй байх нь мөн л хамаатай асуудал боловч “их” байх нь таагүй, “бага” байх нь сайн зүйл байж болно. Хүй нэгдлийн нийгэмд “ид шид” их хамаатай бөгөөд тэдний хувьд сайн зүйл. Гэтэл дундад зууны үеийн европчуудын хувьд энэ нь хамаатай боловч тааруу зүйл.

Үнэт зүйлийг хүсдэг болон хүсүүштэй гэж ялгаж үзэх нь тун чухал. Өөрөөр хэлбэл үнэндээ бодит байдал дээр хүсдэг үнэт зүйл ба хүсэх ёстой гэж үзэж буй үнэт зүйл гэж ялгана гэсэн үг. Эдгээр нь хоорондоо хамааралтай биш бөгөөд ижил байх албагүй. Бодит байдал дээр хүсдэг үнэт зүйл нь олонхын хүлээн зөвшөөрсөн үнэ цэнт зүйл бөгөөд хэмжиж болно. Хүсүүштэй үнэт зүйл нь туйлын буюу ёс суртахууны хэм хэмжээ юм. Хүсдэг үнэт зүйл нь прагматик асуудалтай холбоотой бол хүсүүштэй үнэт зүйл нь үзэл сурталтай холбоотой асуудал юм. Хүсдэг үнэт зүйтээс илүүтэй хүсүүштэй үнэт зүйлийг үзэл суртлаар дамжуулан өөрчилж болно. Иймээс нийгмийн дүрийн үг хэллэг, яриа, бичвэрийн хэлбэр нь хүсүүштэй үнэт зүйлд тусгалаа олдог.

Үнэт зүйлийг бидний (1) бусад хүмүүстэй харилцах харилцаа, (2) бусад юмстай харилцах харилцаа, (3) өөрийн дотоод хүн болон бурхантай харилцах харилцаатай холбоотой хэмээн эрдэмтэд гурван төрөлд ангилан авч үзжээ. Улс төрийн үнэт зүйлийн хувьд эрдэмтэн Rokeach тэгш байдал ба эрх чөлөө гэсэн хоёр хэмжүүрээр авч үзэж, тэгш боловч эрх чөлөө хязгаарлагдмал (коммунист), тэгш байдал, эрх чөлөө хязгаарлагдмал (фашист), эрх чөлөөтэй боловч тэгш байдал хязгаарлагдмал (консерватив), эрх чөлөөтэй, тэгш байдал хангагдсан (социалист) гэж ангилжээ. Bales, Couch нар эрх мэдэл, өөрийгөө хязгаарлах, тэгш байдал, бодгальч байдал гэсэн 4 кластерийг 900 өөр үнэт зүйлээс олон өөр арга ашиглан гаргасан байна. Shalom Schwartz үнэт зүйлсийг эрх мэдэл, ололт амжилт, амьдралд дурлах, сэтгэл хөдлөл, өөрийгөө удирдах, байгаль орчинтойгоо


зохицон орших, халамж, уламжлал, нийцэн зохицох, аюулгүй байдал гэсэн 10 ангилал болгосон байдаг.

Соёл ба үнэт зүйл

Соёл хэмээх ухагдахуун нь өргөн хүрээнд хэлэлцэгдэг асуудал бөгөөд шинжлэх ухааны салбар бүр өөр өөрийн байдлаар тодорхойлсон байдаг. Соёл судлаач Б.Сумъяа (Сумъяа, 2001) “Соёл гэдэг байгаль орчин, нийгэм-түүхийн тодорхой нөхцөлд хүний өөрийнх нь боловсрон хөгжиж буй хэр хэмжээ, хүний ухамсартай үйл ажиллагаагаар дамжин материаллаг болон оюунлаг үнэт зүйлсэд шингэсэн, шингэж буй оюун ухаан, авьяас билиг, ур чадвар, итгэл бишрэл, зан суртахууны болон гоо сайхны төсөөлөл, эрмэлзэл, эрхэмлэл, тэдгээр үнэт зүйлсийг бүтээх, өвлөн уламжлах, дэлгэрүүлэх, эзэмшин ашиглах арга хэлбэр, хэрэгслийн тогтолцоо мөн” гэж тайлбарлажээ. Харин ЮНЕСКО-гийн тунхаглалд (UNESCO, 2002) “Соёл гэдэг нь нийгмийн ухаан бодол, оюун санаа, сэтгэлийн хөдөлгөөний онцлог шинжүүдийн цогцлол мөн бөгөөд зөвхөн төрөл бүрийн урлагийг төдийгүй, аж төрөх ёс, хүний оршин амьдрахуйн үндсэн ёс журам, үнэт зүйлс, уламжлал, итгэл бишрэлийн тогтолцоог өөртөө багтаадаг” гэжээ.

Судлаач Гийрт Хофстед дэлхий нийтийн соёлын хүрээнд авч үзэхдээ (Hofstede G. , 2001) “Оюун ухааны нэгдсэн програмчлал” гэж тайлбарласан бөгөөд энэхүү нэгдсэн програмчлал нь бүлэг, нийтлэг, үндэстэн угсаатныг бусдаас ялгах, ялгаруулах гол шалтгаан болдог байна. (Зураг 1)

Зураг 1 Хүний оюун ухааны програмчлалын 3 шат




Эх сурвалж: (Hofstede G. , 2001)

Оюун ухааны програмчлалын эхний түвшин нь газар нутаг, хил хязгаараар хуваагдаж, өөр хоорондоо ялгаршсан ч хүн гэдэг утгаар нэгэн ижил тайлбарлагдах хүн төрөлхтөн нийтийн зан үйл юм. Иймээс энэ оюун ухаант үйлээр хүн бие биеэс ялгардаггүйгээр барахгүй дээд амьтдад хүртэл илэрдэг байна. Харин бүлгийн буюу үндэстэн, угсаатны програмчлалыг бид өөрийн нийгэм дотроо бий болгосон байдаг; энэ шинж нь хэсэг бүлэг хүмүүст нийтлэг хэдий ч бусад бүлэгт нийтлэг биш зан үйл юм. Иймээс ерөнхийлөн хэлбэл дэлхий дээр байх бүх үндэстэн, угсаатны соёл энэ түвшинд хамаарагддаг. Харин бие хүний түвшинд нэг бие хүн байтугай ихэр хүмүүст ч давтагдашгүй байдаг биологийн болон нийгмийн зарчмын дагуу хүн бүрт өөрөөр оюун ухааны програмчлал суудаг. Оюун ухааны энэхүү програмчлал удамшиж болохын зэрэгцээ хүүхэд төрмөгц тогтож эхэлдэг байна.

Үндэстэн угсаатны оюун ухааны програмчлал нь өөрийн итгэл үнэмшил, хандлагад суурилсан бодол санаа, дүгнэлт, мэдрэмж, үйл үйлдлийг илэрхийлж байдаг. Тэгэхээр хүний үйлээр бий болж буй соёлын тухайн илэрлүүд нь олон давхрагат үйл ажиллагаагаар тодорхойлогдож, байнгын өөрчлөлт хувьсалд орших хэдий ч түүний гүнд байх үнэт зүйл өөрчлөгдөхдөө удаан байдаг. Үүнийг соёлын сонгинон загвараар (Зураг 2) дүрсэлж болно.

Зураг 2 “Соёлын сонгинон загвар”



Эх сурвалж: (Hofstede G. , 2001)

Соёлын сонгинон загварын өнгөн хэсэгт харагдах элементүүд байрлаж түүний гүнд үнэт зүйл оршиж байдаг. Үнэт зүйл бүр соёлоос шалтгаалан өөр өөрөөр тодорхойлогдоно. Бэлгэдэл, тухайн нийгмийн баатар, уламжлал нь соёлын гадна харагдах элементүүд бөгөөд бэлгэдэл нь үг, хөдөлгөөн, зураг, биет зүйлээр, баатар нь тухайн соёл дахь өнгөрсөн түүхэн дэх болон одоо амьдарч буй, жинхэнэ эсвэл төсөөллөөр хэлбэржсэн, тухайн нийгмийн баатрын дүрээр, уламжлал нь зан заншлын нийлбэрээр илэрнэ. Энэ бүхний гүнд хэзээ ч өөрчлөгддөггүй, ямар ч төрлийн шийдвэр, үйл хөдлөлд шаардлагатай үнэ цэнт зүйл буюу үнэт зүйл байдаг ажээ.

Соёлын үнэт зүйлийн судалгааны тойм

Үндэсний соёл нь үнэт зүйлийн системээс бүрдэн бий болох бөгөөд тодорхой нэгэн нийгэм, бүлгийн хувьд нийтлэг байхын хамт бие хүний хандлагыг тодорхойлдог (Hofstede G. , 2001), сэтгэн бодох, мэдрэх, илэрхийлэн гаргах үйлдлийг ч загварчилсан байдаг (Biljana, 2009) учир соёлыг бид зөвхөн нэг хүнд хамааруулан авч үзэх нь тохиромжгүй юм. Харин хүн нийгмийн харилцаанд (энд бүх төрлийн нийгмийн бүлгийг авч хэлэлцэнэ, жишээлбэл, гэр бүл, найз нөхөд, ураг төрөл, угсаатан, үндэстэн гэх мэт) орохдоо нийгмээсээ сурсан соёлын програмчлалын (Hofstede G. , 2001) дагуу хариу үйлдэл хийдэг байна. Иймээс бидэнд суусан соёлын үнэт зүйлс хийж буй үйлдэл бүрт, гаргаж буй шийдвэр бүрт, хүлээн авч буй үйлдэлд үзүүлэх хариу үйлдэл бүрт илрэх бөгөөд түүнийг ойлгох арга зам нийгмийн бүлгийн хувьд нийтлэг шинжтэй байдаг аж.

Эрдэмтэд соёлыг хэмжих олон төрлийн, янз бүрийн түвшингийн аргачлалыг хөгжүүлж, тодорхойлсон байдна. Тухайлбал, судлаач Халл нь хүмүүс хоорондын харилцаа хэл яриа, биеийн хөдөлгөөнөөр илрэхдээ соёлын ялгаанаас хамааран утгын холбогдол өндөр ба утгын холбогдол багаар илэрдэг (Graham, 2010) гэжээ. Утгын холбогдол өндөр нийгэмд харилцаа холбоо үг хэлээс илүүтэйгээр үйл хөдлөл, нүүр царайны хувирал, тойруу утгаар ойлгуулах, цаг хугацааг зөв олох зэргээс хамаарал өндөртэй (Reiche, Lee, & Javier, 2009)

байдаг. Харин мэдээллийн утгын холбогдол бага нийгэмд хүмүүс хоорондын харилцаа шууд илрэх бөгөөд сэтгэлийн хөдлөл бага, албаны харилцаатай байдаг. Ази, Африк, Ойрх Дорнодын орон болон Япон (Graham, 2010), Хятад зэрэг улсуудтай адилаар Монгол Улс мэдээллийн утгын холбогдол өндөр (Tuvshinzaya, 2008) улсад хамаарагддаг байна.

Хүн судлаач Клакон, Стродбек (1961) нар соёлыг нийгэм дэх хүн хоорондын харилцаа, хүн орчны харилцааны зураглал хэмээн тодорхойлж (Reiche, Lee, & Javier, 2009), “Би хүмүүсийн талаар хэрхэн боддог вэ?”, “Би ертөнцийг хэрхэн хардаг вэ?”, “Би бусадтай ямар хамааралтай вэ?”, “Би цаг хугацааг хэрхэн үздэг вэ?” гэсэн дөрвөн энгийн асуултад хариулж, зургаан соёлын үнэт зүйлийг тодорхойлсон (Marta, Caroline, Joseph, Niels, & Pei-Chuan, 2002) байна. Үүнээс гадна Хофстедийн аргачлалд нэмэр болох Тромпанер, Хампден-Турнерийн (1997) хүн гадаад орчиндоо хандах хандлагад тулгуурласан соёлын 7 үнэт зүйл бүхий аргачлал (Graham, 2010) бий ч Хофстедийн аргачлал шиг нийтлэг, стандартчилагдсан болж чадаагүй (Kats, Emmerick, John, & Svetlana, 2010) гэж дүгнэсэн нь бий. Мөн Шалом Шварц (1987) 60,000 хүнээс амьдралдаа мөрддөг нийтлэг зарчмынх нь талаар судалгаа авч, нийтлэг 7 соёлын үнэт зүйлийг тодорхойлсон байна. Шалом Шварц нь Хофстедийн аргачлалыг бие хүний хувьд биш үндэсний үнэт зүйлийн ялгааг гаргагдгаас гадна ажлын үнэт зүйлд суурилсан судалгаа байдаг тул үндэстэн, угсаатны нийтлэг үнэт зүйлийг төлөөлж чадахгүй юм (Kats, Emmerick, John, & Svetlana, 2010) гэж шүүмжилсэн нь бий. Гэвч дээр дурдсан аргачлалуудтай харьцуулахад Хофстедийн арга нь хамгийн олон эш татагдсан (Charles, et al., 2014), хамгийн өргөн хэрэглэгддэг (Boonghee, Naveen, & Tomasz, 2011), (Bo, et al., 2013), сайн танигдсан (Kats, Emmerick, John, & Svetlana, 2010), нийгмийн ухаан, менежментийн чиглэлийн олон соёлын харьцуулсан судалгаанд өргөнөөр ашиглагддаг (Graham, 2010), (Boonghee, Naveen, & Tomasz, 2011), (Habte, 2010), соёлын гол үнэт зүйлсийг гаргаж ирж чадсан (Boonghee, Naveen, & Tomasz, 2011), судалгааны үр дүн улс орны хүн амзүй, газарзүй, эдийн засаг, улс төрийн индикатортой хамаарал өндөр (Boonghee, Naveen, & Tomasz, 2011) гэж судлаачид дүгнэжээ.

Гийрт Хофстедийн соёлын үнэт зүйлийг хэмжих аргачлал нь 4 жилийн хугацаанд цуглуулсан 60 орны 116,000 ажилтны судалгаанд үндэслэн (Biļjana, 2009) эрх мэдлийн ялгаа, бодгальч ба хамтач, тодорхойгүй байдлаас зугтах, маскулин ба феминин гэсэн соёлын 4 үнэт зүйлийг тодорхойлсон бол 1987 онд тав дахь хэмжүүр болох урт хугацаанд чиглэх хандлага (Graham, 2010), 2011 онд чөлөөт ба баригдмал (Charles, et al., 2014) хэмээх зургаа дахь хэмжүүрийг нэмсэн байна. Эрх мэдлийн ялгаа (power distance) нь нийгэмд эрх мэдэл ялгаатай хуваарилагдсан байхыг хүлээн зөвшөөрөх байдал, бодгальч (Individualism/collectivism) нь хүмүүс зөвхөн өөрийгөө болон өөрийн гэр бүлийн хүмүүсийг тойлон халамжилдаг, эсрэгээрээ хамтач соёл нь өөрийн харьяалагдах бүх бүлэгтээ хүчтэй нэгдэж, амьдралын явцад тэднийг хамгаалах, үнэнч байхыг эрхэмлэнэ. Тодорхойгүй байдлаас зугтах (uncertainty avoidance) нь хүмүүс эргэлзээтэй, тодорхойгүй байдлыг бий болгохгүйн тулд түүнийг эсэргүүцэж, даван дийлэхийн тулд дүрэм бий болгох байдал, маскулин (masculinity/femininity) соёл нь хүчтэй, дайчин шинж давамгайлсан, амжилт, ашиг орлогыг илүүд үзэх бол эсрэгээрээ феминин соёл нь сэтгэл ханамж, бусдыг халамжлах, амьдралын сайн сайханд хандах шинж давамгайлдаг байна. Урт хугацаанд чиглэх хандлага (long-term orientation) нь ирээдүйгээ харж, түүнд

зориулан үйлдэл хийх бол эсрэгээрээ богино хугацаанд хандах хандлага өнгөрсөн ба одоод төвлөж, одоо хүрэх ашиг сонирхлыг илүүд үзнэ. Сүүлийн үнэт зүйл болох чөлөөт ба баригдмал байдал (indulgence/restraint) нь нийгэм хувь хүний хүсэл мөрөөдөл, эрх чөлөөг хэр их хүлээн зөвшөөрч байгаагаар илэрхийлэгддэг (Hofstede G. , 2001), (Charles, et al., 2014) ажээ. Хофстедын аргачлалаар монголчуудын үнэт зүйлийг маркетингтай холбон судалсан (Tuvshinzaya, 2008), монгол оюутнуудын үнэт зүйлийг тодорхойлсон (Charles, et al., 2014) зэрэг судалгааг дурдаж болно.

Дараах хамаарлууд Хофстедийн судалгааны явцад тодорхойлогдсон (Tuvshinzaya, 2008), (Hofstede G. , 2001) байдаг. Үүнд:

- Power distance

- Дулаан цаг ууртай орнуудад эрх мэдлийн тэнцвэргүй байдал илүү ажиглагддаг бол хүйтэн сэрүүн уур амьсгалтай орнуудад тэнцвэргүй байдал бага ажиглагддаг.
- Цөөн хүн ам нь эрх мэдлийн зааг ялгаа бага байх үндэс нь болдог. Иймээс хүн амын нягтшил нь эрх мэдлийн зааг ялгаатай эерэг хамааралтай.
- Эрх мэдлийн зааг ялгаа бага байх тусам нийгмийн доод давхраа боловсролтой болох шаардлага бий болж, дунд давхрааныхан нийгмийн хөгжлийг авч явж эхэлдэг.

- Uncertainty avoidance

- Тодорхойгүй байдлаас зугтах хандлага ба газарзүйн байрлал ядуу улс оронд эерэг, чинээлэг улс оронд сөрөг хамааралтай.
- Түүхэн явцаас харахад нийгмийн хуулийг хэрхэн үзэж буй, хэн гаргаж буйгаас шалтгаалан тодорхойгүй байдлаас зугтах хандлага өөрчлөгддөг байна. Жишээлбэл, Майкел Харрис Бонд “Хятадын соёлд хууль дүрмийг удирдагчид бий болгодог; Өрнийн соёлд хууль бол хууль байх бөгөөд удирдагчдаас хамгаалахын тулд бий болдог” гэсэн байдаг.

- Individualism

- Индивидуализм нь баялгийн хэмжээтэй хүчтэй хамааралтай. Баялгийн хэмжээ багатай орнуудад коллективист нийгэм ажиглагддаг.
- Цаг уур индивидуалист байдалд нөлөөлж байна. Дулаан уур амьсгалтай орнуудад нийгэм нь илүү индивидуалист, хүйтэн сэрүүн уур амьсгалтай орнуудад илүү коллективист нийгэмтэй байх нь ажиглагддаг.
- Цөм /nuclear/ буюу аав ээж, хүүхдээс бүрдсэн гэр бүл нь өргөжсөн гэр бүл буюу аав ээж, эмээ өвөө, үр хүүхэд, хамаатан саднуудаас бүрдсэн гэр бүлээс илүүтэй индивидуалист байдлын шалтгаан болон нөлөө нь болж өгдөг. Монгол гэр бүлийн ихэнх нь өргөжсөн гэр бүл юм.

- Masculinity/femininity

- Маскулин шинж маш хүйтэн болон хэт халуун орнуудыг бодвол дулаан уур амьсгалтай орон илүү өндөр байдаг байна.
- Нийгэмд өрсөлдөөн бий болох тусам маскулин шинж илүүтэйгээр илэрдэг бол оршин тогтнож үлдэхийн тулд өөр хоорондоо хамтарч эхлэхэд маскулин шинж буурдаг.
- Мөн түүхэн талаас эрэгтэйчүүд дайн тулаан, ан гөрөөнд явж, гэрээс холдох тусам эмэгтэйчүүдийг өрх гэрээ авч явах хариуцлага, шаардлага нэмэгдэж, нийгэм маскулин шинжтэй болж эхлэх хандлагатай байжээ.

- Long term orientation/short term orientation

- Күнзийн соёлтой улс орнуудад урт хугацаанд хандах хандлага илүү өндөр байх хэдий ч дэлхийн бусад улс орнуудад ч бий.
- Тэсвэр тэвчээртэй, хадгалах хандлагатай, бусадтай харилцахдаа ялгамжтай (ах зах гэдэг утгаар) ханддаг, ёс суртахуунлаг бол урт хугацаанд хандах хандлагын нэг туйл бол нөгөө туйл нь хувийн тогтвортой байдал, зөвхөн өөрийнгөө хамгаалах, уламжлалаа хүндлэх, мэнд мэдэх, бэлэг өгөх нь хариутай байх юм.

Үндэсний соёлын талаар тэр дундаа соёл хоорондын хөндлөн харьцуулалт хийдэг хэд хэдэн аргачлал байдаг бөгөөд эдгээрийг харьцуулбал дараах байдалтай байна.

Судлаачын нэр	Geert Hofstede	Milton Rokeach	Shalom Schwartz
Судалгааны хувилбарууд	VSM82, VSMM94, VSM08, VSM2013 (Value Survey Model)	RVS-Rokeach Value Survey	SVS PVQ PVQ-R
Судалгааны хэмжүүрүүд	Нийтлэг 6 үнэт зүйл	Нийтлэг 2 үнэт зүйл – 36 хувьсагч	10 нийтлэг үнэт зүйл – 19 хувьсагч
	<p>PDI- Эрх мэдлийн хоорондын ялгаа заагийн индекс-IND- ндивидуализм/коллективизм</p> <p>MAS- Masculine /Feminine</p> <p>UAI- Тодорхойгүй байдлаас зугтах түвшин</p> <p>LTO- Урт хугацаанд чиглэх нь</p> <p>IVR - Indulgence versus Restraint Index – өөрийн сэтгэл хангалуун байдалд анхаарах</p>	<p>Terminal Values – чухал үнэт зүйлс</p> <p>Үнэнч нөхөрлөл, Тогтвортой/төлөвшсөн хайр, Өөрийгөө хүндлэх, Аз жаргал, Өөрийгөө хүлээн зөвшөөрөх, Тэгш байдал, Эрх чөлөө, Сэтгэл хангалуун байдал, Нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөх, Цэцэн ухаан, Оюун санааны аврал, Гэр бүлийн аюулгүй байдал, Үндэсний аюулгүй байдал, Ололт амжилтын мэдрэмж, Гоо сайхны мэдрэмж, Дэлхийн энх тайван, Тав тухтай амьдрал, Адал явалтай амьдрал</p> <p>Instrumental Values – дэмжих үнэт зүйлс</p> <p>Сэргэлэн цовоо байдал, Хүсэл тэмүүлэл, Хайр, Цэвэрч, нямбай зан, Биеэ барих зан, Чадавхи, Эр зориг, Эелдэг чанар, Шударга зан, Уран сэтгэмж, Бие даасан байдал, Оюуны чадавхи, Өргөн</p>	<p>Өөрийгөө удирдах Self-direction, Өөрийн гэсэн үзэл бодол, үйл хөдлөл, аливаа зүйлийг бие даан хийх, төлөвлөх, бүтээх</p> <p>Сэтгэл хөдлөх, Шинэлэг байх, Өөрчлөгдөх, Stimulation, Сэтгэл хөдлөл=хөөрөл, шинэлэг байдал, сайхан амьдралын төлөө тэмцэх</p> <p>Гедонизм-Амьдралд дурлагч, Hedonism, Өөртөө болон амьдралд сэтгэл хангалуун, таатай байх, талархаж байх</p> <p>Ололт амжилт, Achievement, Авьяас чадвар, мэдлэгээ харуулах байдлаар хувийн амжилтанд хүрэх</p> <p>Эрх мэдэл, Power, Нийгмийн статус- нэр хүнд, нөөц эсхүл хүмүүсийг хянах эсвэл давамгайлах байдал</p> <p>Аюулгүй байдал, Security, Аюулгүй байдал, эв эе, нийгмийн харилцааны тогтвортой байдал, тэгш эрхийн зарчим</p> <p>Нийцэн зохицох, Conformity, Аливаа үйлийг хязгаарлах, биеэ барих, буулт хийх таарч тохирох, эсхүл бусдад хохирол учруулах болон нийгмийн нормыг зөрчихгүй байх</p> <p>Уламжлал, Tradition, Ёс заншил улмажлалт зан үйл, сүсэг бишрэлийн зүйлийг хүндэтгэх, тэдгээрт үнэнч байх</p> <p>Халамж, энэрэл, Benevolence, Тусч байх, үнэнч, уучламтай, найдвартай, үгнээс гардаггүй, үнэнч нөхөрлөл, сэтгэлээсээ хайрлах хайр гэх мэт</p>

		хүрээтэй сэтгэх чадвар, Логик сэтгэлгээ, Хүлцэнгүй байдал, Тусархаг, Үүрэг хариуцлагатай, Өршөөл уучлал	Универсализм, Universalism, Өргөн хүрээний мэдлэг боловсрол, нийгмийн шударга байдал, эв тэгш байдал, дэлхий дахины энх тунх, гоо ертөнц, байгаль орчинтойгоор зохиролтой оршин тогтнох, оюун ухаан, байгаль орчныг хамгаалах
--	--	---	---

Hofstede 1967 оноос 1973 оны хооронд хоёр үе шаттай судлагаа явуулж 72 орноос 116000 санал асуулгын хуудсаар хариулт авч үнэ цэнэт зүйл /value/ болон хандлага дахь ялгааг тодорхойлсон. Судалгаанд анх IBM корпорацийн олон орон дахь салбаруудын ажилтнууд хамрагдсан байна. Эхний судалгаа шинжилгээнд нь 40 орноос тус бүр 50-иас дээш тооны хүн хамрагдсан. Дараагийн шатанд нь 10-аас дээш орон болон олон улсуудаас бүрдсэн гурван бүс нутаг нэмэгдэж хамрагдсан байна (Hofstede, G. (2001.p-41). 1980-аад онд Хонконг дахь Хятадын их сургуулийн профессор Michael Harris Bond-ийн явуулсан Хятадын Үнэ цэнэт Зүйлийн Судалгааны явцад түүний “Confucian work dynamics” хэмээн нэрлэсэн соёлын хэмжүүр тодорхойлогдсон. Түүнийг Hofstede сүүлд “Урт хугацааны хандлага” хэмээн нэрлэсэн бөгөөд соёлын 5 дахь хэмжүүр болгон хэрэглэх болсон байна.

Соёлын ялгааг түүхийн судалгаагүйгээр ойлгох боломжгүй юм. Учир нь соёлын ялгаа болон ижил төстэй байдал нь түүхийн маш эртний ул үндэстэй байдаг. (Hofstede, G. (2001) pp. 11-12). XIV зуунд амьдарч байсан эрдэмтэн Ibn Khaldun нүүдэлчин болон суурьшмал амьдралтай хүмүүсийн менталитет, боловсрол болон нийгмийн зан төлөв нь өөр [Hofstede, G. (2001) p. 13] болох тухай өөрийн Al Mugaddima номдоо бичсэн байдаг байна.

СУДАЛГААНЫ АРГА, АРГАЗҮЙ:

Уг судалгаанд дараах арга зүйг ашиглана.

- Ном зүйн тойм /Түүхэн баримт бичиг, судлаачдын бүтээлүүдэд хийх судалгаа/
- Асуулга – VSM2013
- Хэлэлцүүлэг, ярилцлага
- Эксперт үнэлгээ зэргийг ашигласан болно.

VSM 2013-ийн зорилго: Үндэсний хэв маягийг (онцлогийг) харьцуулах нь

Үндэстний үнэт зүйлийн судалгааны VSM 2013 загвар нь хоёр болон түүнээс дээш улс эсвэл тухайн улсын зарим бүс нутгийн судалгаанд оролцогчдын соёлоос хамаарах үнэт зүйл болон хандлагыг харьцуулан судлахын тулд боловсруулсан 30 зүйл-цаасан болон харандаан санал асуулга юм.

Энэ нь үндэстний үнэт зүйлийн 6 хэмжүүр тус бүрээр 4 асуулт бүхий нийтдээ 24 асуулгад тулгуурлан үнэлдэг. Мөн бусад 6 асуулт нь оролцогчийн хүйс, нас, боловсролын түвшин, ажил мэргэжил, яс үндэс болон төрсөн газар нутаг гэсэн ерөнхий мэдээллийг агуулдаг байна.

Энэхүү 6 хэмжүүр нь Geert Hofstede болон түүний хамтран судлаачдын судалгааны ажлаар тодорхойлогдсон бөгөөд Hofstede-ийн 3 дах хэвлэл, Hofstede болон Minkov нарын 2010 оны бүтээлд нэлээн өргөн цар хүрээтэй тайлбарлагдсан байдаг. Тэд үндэстний нийгмийн чухал асуудалтай холбон авч үзсэн.

Үнэт зүйлийн судалгааны хэрэглүүр (VSM 82)-ийн хамгийн анхны нийтийн хүртээл болсон хувилбар 4 хэмжүүртэй байсан ба энэ нь 40 орон дахь IBM корпорацийн салбар компаниудын харьцуулалтаас гарч ирсэн байна. Дараагийн хувилбар (VSM 94) нь 5 хэмжүүртэй ба нэмэлт хэмжүүрийг үндсэндээ Хятадын судлаачдын гаргаж

тодорхойлсон асуулга судалгааг ашиглан 23 улсын оюутнуудыг харьцуулахдаа олж тодорхойлсон (Hofstede & Bond, 1988). Үндэстний үнэт зүйлийн судалгааны одоогийн хувилбарын 6 дахь хэмжүүрийг Minkov-ийн 81 улсад хийгдсэн Дэлхийн Үнэт зүйлийн судалгаанаас гаргаж ирсэн.

Судалгааны туршлагаас 24 асуултанд хариултад санал асуулгад оролцогчдын яс үндэс нөлөөлдөг болох нь харагдсан. Энэ нь А үндэстэнээс санал асуулгад оролцогчид бүр нэг ижил хариулт өгдөг гэсэн үг биш боловч А болон В үндэстнүүдийн хариулт нь системтэй ялгаатай байж болох юм. Харилцан хамааралын хувьд статистик ая холбогдолтой байхын тулд, тухайн улс орон бүрийн түүвэрийн хэмжээ хангалттай байх хэрэгтэй. Нэг ижил төрлийн түүврийн хамгийн тохиромжтой хэмжээ нь 50 оролцогч байна.

24 асуултын хариултад судалгаанд оролцогчдын нас, хүйс, боловсролын түвшин, ажил мэргэжил, асуулгад хариулах цаг үе зэрэг бусад шинж чанар нөлөөлж болно. Иймээс улс орнуудын харьцуулалт нь асуулга судалгааны хариултад системтэйгээр нөлөөлж болох үндэстнээс бусад бүх шалгуурт нийцэх судалгаанд оролцогчдын түүвэрт үндэслэн байх хэрэгтэй.

VSM 2013 нь хувь хүмүүсийг харьцуулахад ашиглагдахгүй.

Дээр дурдсанчлан, VSM-р хэмжигдэх хэмжүүрүүд нь улс үндэстнүүдийн түүврийн дундаж үнэлгээний **улсын түвшиний** корреляцид тулгуурладаг. Ижилхэн 2 асуултын хувьд, улсын түвшиний корреляци нь тухайн орны түүвэрт хамрагдсан хувь хүмүүсийн хариултауд хоорондох хувь хүний түвшиний корреляциас нэлээд ялгаатай байж болно (илүү тодорхой тайлбарыг Klein, Dansereau & Hall, 1994-с харна уу). Хувь хүний түвшиний корреляци нь хэмжүүрийг харуулдаг.

Үндэстний соёлын хэмжүүрийн судалгаа нь антропологид хамаарах ба бие даасан хувь хүний зан төлвийн судалгаа нь сэтгэл зүйн судалгаанд хамаарагдана. Эхлээд ойг судлаад дараа нь модыг судлахтай адил юм. Ойг мод гэж ижил хэмжүүрээр тайлбарлаж болохгүй ч гэсэн модны салбар гэж ойлгож болно.

Үндэстний соёлын хэмжүүрүүдийн талаарх нийтлэг буруу ойлголт бол хувь хүний төрөл байдаг. Хүмүүс хэмжүүрээр өөрсдийгөө үнэлэхийг хүсдэг эсвэл бусдаар үнэлүүлэхийг хичээдэг. Үүнийг хэвшмэл ойлголт ч гэж нэрлэдэг боловч энэ нь ямар нэгэн хэмжүүр биш юм. Тэдгээр нь хувь хүнтэй холбоогүй ч тухайн улсын нийгэмтэй холбоотой байдаг. Бие хүн болох хүн тухайн улсын нийгмийн үнэт зүйлсийг хэрхэн ойлгож мэдэрч байгаагаа илэрхийлж болно, гэхдээ энэ нь одоо ч гэсэн хувь хүний үүрэг болохоос биш тухайн үндэстний соёлыг харуулах шаардлагагүй юм. Тиймээс, үнэт зүйлийн судалгааны VSM 2013-ийг хувь хүний түвшинд үнэлгээ хийхгүй. Энэ нь сэтгэл зүйн тест биш юм. Үнэт зүйлийн судалгааны VSM загварыг зөвхөн бусад нийгэмээс ялгаатай нийгмийн үзэл баримтлалыг бүртгүүлэх судлаачид ашиглах нь зүйтэй юм.

VSM 2013 нь байгууллагыг харьцуулахад ашиглагдахгүй.

VSM 2013-ийн 6 хэмжүүрийг 40 гаруй улс орнуудад хийгдсэн судалгаандаас гаргаж ирсэн. Мөн ижил төсөөтэй хоёр орны өөр хоорондоо ялгаатай 20 байгууллага дээр хийгдсэн судалгааны төслийн хувьд асуултад хариулсан хариултаар улс үндэстэн хоорондын хэмжүүрийг ижил арга замаар хамаарал тооцох боломжгүй. (Hofstede, Neuijen, Ohayv, Сандерс, 1990, Hofstede, Hofstede & Minkov -д хамааралтай биш үү хүртэл хийсэн 2010: 341-368). Тиймээс улс үндэстэн хоорондын хэмжээс нь

байгууллагын (эсвэл аж ахуйн нэгжийн) соёлтой нийцэхгүй байна. VSM асуултын (үнэт зүйлс, үзэл шийдвэрлэх) хариултууд улс орон даяар гэхээс илүү тухайн улсын байгууллагууд бага зэрэг ялгаатай. Харин, байгууллагын соёл практик ойлголтоос гол төлөв ялгаатай бөгөөд судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд хүлээгдэж буй практик зургаан хэмжээсээр дээр харьцуулж болох юм.

Үндэсний соёлын судалгаа нь антропологийн хамаарах, хувь хүний сэтгэл судлалтай холбоотой судалгаа болон социологитой холбоотой байгууллагын соёлын судалгаа хамаарна. Ижил төстэй асуудал ажил мэргэжил (: 368-369 Hofstede, Hofstede & Minkov, 2010) харьцуулах VSM хэмжээсийг хэрэглэхийг хориглодог.

VSM 2013-ийн үнэлгээ нь нийтэд танилцуулсан үнэлгээтэй харьцуулагдахгүй.

VSM 2013 нь сурган заах аргазүйн хэрэгсэл биш юм

VSM 2013 нь судалгааны зорилгоор бүтээгдсэн байна. Антропологи эсвэл cross cultural судалгааны талаар мэргэжлийн сургалт аваагүй оюутан эсвэл сонсогч нарын хувьд VSM нь үнэт зүйлийн хэмжүүрийг тайлбарлахад чухал хэрэгсэл болж чадахгүй.

VSM 2013-ийн найдвартай байдал

IBM-ийн мэдээллийн сан (Hofstede, 1980) анх 40 улс орнуудын хувьд эхний 4 хэмжүүрийн Cronbach альфа тооцсон. Үүнд:

Эрх мэдлийн ялгаатай байдлын индекс (3 зүйл): Alpha = .842

Бие даасан индекс (6 зүйл): Alpha = .770

Masculinity индекс (8 зүйл): Alpha = .760

Тодорхойгүй байдлаас зайлсхийх индекс (3 зүйл) Альфа = .715

VSM 2013-ийг хэрэглэх нөхцөл


VSM 2013 нь зохиогчийн эрхтэй боловч академик судалгааны ажлуудад шууд ашиглах боломжтой.

VSM 2013-ийг ашиглахыг хүссэн зөвлөхүүд хуулбарласан тооноос хамаарч жил бүр хураамж төлнө.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН БҮТЭЦ


Хүйс

	Frequency	Percent
Эрэгтэй	1652	39%
Эмэгтэй	2540	61%




Нас

	Frequency	Percent
20-с доош	487	12%
20-24	819	19%
25-29	620	15%
30-34	444	11%
35-39	441	10%
40-49	947	22%
50-59	370	9%
60 ба түүнээс дээш	85	2%




Боловсрол

	Frequency	Percent
10-с бага	551	13%
11 жил	329	8%
12 жил	330	8%
13 жил	310	7%
14 жил	1143	27%
15 жил	548	13%
16 жил	458	11%
17 жил	238	6%
18 ба түүнээс дээш	307	7%
Нийт	4214	100.0




Ажил

	Frequency	Percent
Цалингүй ажил эрхэлдэг эсвэл оюутан	893	21%
Мэргэжилгүй буюу богино хугацааны сургалтанд хамрагдсан ажилчин	296	7%
Сургалтанд хамрагдсан офисийн ажилтан эсвэл нарийн бичиг	118	3%
МСҮТ, ТМС, Техникумд мэргэжил эзэмшсэн ажилтан	364	9%
Их дээд сургууль төгссөн ажилтан гэхдээ хүн удирддаггүй	1429	34%
Анхан шатны менежер	616	15%
Дунд буюу түүнээс дээш шатны менежер	478	11%



1	Архангай	134	3.2%
2	Баян-Өлгий	31	0.7%
3	Баянхонгор	101	2.4%
4	Булган	73	1.7%
5	Говь-Алтай	122	2.9%
6	Говьсүмбэр	12	0.3%
7	Дархан	98	2.3%
8	Дорноговь	55	1.3%
9	Дорнод	59	1.4%
10	Дундговь	118	2.8%
11	Завхан	207	4.9%
12	Өвөрхангай	196	4.7%
13	Өмнөговь	49	1.2%
14	Сүхбаатар	50	1.2%
15	Сэлэнгэ	113	2.7%
16	Төв	142	3.4%
17	Увс	143	3.4%
18	Улаанбаатар	2024	48.0%
19	Ховд	123	2.9%
20	Хөвсгөл	99	2.3%
21	Хэнтий	158	3.7%
22	Эрдэнэт	92	2.2%
23	Бусад /Гадаадад төрсөн/	15	0.4%



СУДАЛГААНЫ ҮР ДҮН – ҮЗҮҮЛЭЛТ ТУС БҮРЭЭР

1. ХАМТАЧ БОЛОН БОДГАЛЬЧ БАЙДАЛ (INDIVIDUALISM VS COLLECTIVISM)

№	COL/IDV	
1	<p>Судлах үндэслэл</p>	<p>Монголчууд өргөн уудам газар нутагт нягтрал багатайгаар төдийгүй нүүдэллэн амьдардаг нь нүүдэлчдийн үйлдвэрлэл ахуйг суурин орны үйлдвэрлэл ахуйгаас ихээхэн ялгаатай болгодог(Д.Төмөртоогоо.2006.р-31). Эрс тэс байгал цаг ууртай нөхцөлд бэлчээр хөөн нүүдэллэх мал аж ахуйн үйлдвэрлэл нь ихэвчлэн хамаатан саднаараа хот айл үүсгэн хамтын хөдөлмөрөөр аж ахуйгаа эрхлэхэд хүргэдэг. Энэ нь монголчуудыг гэр бүлийн болон хамаатан садан, хот айлынхны хүрээнд хамтран, хамтач байх нөхцөл болж өгдөг.</p> <p>Монгол айл өрх бүр өөрөө үйлдвэрлэлийн нэгж болдог нь суурин иргэншлийн аж ахуйгаас ялгааг бий болгож байна. Энэ нөхцөл байдлаас монголчууд аливаа асуудалд нилээд биеэ даасан байдалтайгаар шийдвэр гаргахад хүргэдэг. Үүнийг зарим эрдэмтэд монголчууд хамтач биш бөгөөд үүнд дээрх нөхцөл байдал нөлөөлсөн гэж дүгнэх нь бий. Хэдий монголчууд таруу байршиж, биеэ даан амьдардаг хэдий ч гэр бүл, хамаатан садны хувьд хамтач соёлын хэм хэмжээ хүчтэй илэрдэг. Улс үндэстнүүдэд тэр бүр</p>

байдаггүй нэг заншил бол бусдыг зочлох, ялангуяа зам зуурын хүмүүст ч халамж анхаарал тавьдаг явдал юм.

Суурин иргэншилт газруудад олноор нэг дор суурьшин аж ахуйгаа эрхлэн бие биенийхээ хэрэгцээг хангадаг. Ийм соёл иргэншилт орнуудын дотор коллективист нийгэм ч, индивидуалист нийгэм ч тааралдаж байна. Нүүдлийн иргэншилд байхдаа төдийгүй суурин соёл иргэншил рүү орж ирсэн хойноо ч гэр бүл хамаатан, айл саахалтынхан гэх мэт бүлгүүдийнхээ хувьд хамтач шинж нь хэвээрээ л байна. Өнөө цагт ч ажиглагддаг монголчуудын нутгархаг үзэл нь хамтач соёлын үед илэрдэг өөрийн хамааралтай бүлгийг хамааралгүй бүлгээс ялгаж ханддаг хэм хэмжээний илрэл юм.

Монголчуудын хувьд ХХ зуунд суурьшмал иргэншил руу шилжиж эхэлсэн. Гэтэл шинэ иргэншлийн дотор монголчуудын хувьд нийгмийн хэмжээнд “бид” гэсэн ухамсар суусан эсэх нь эргэлзээтэй гэж зарим эрдэмтэд үздэг. Хот суурин газруудад олноор суурьшихдаа таруу байснаасаа ч илүү хүнийрхүү байдалтайгаар аливаад хандах болсон гэж шүүмжилж байна.

20-р зуун гарсаар монголчуудын нийгэм, соёлын өөрчлөлт тухайлбал малчдыг нэгдэлжүүлэх оролдлого, социализмын үндэс суурийг бий зэрэг өөрчлөлтүүд гарсан нь хамтач нийгмийг тунхаглаж байв.

Нийгмийн мини модел болох гэр бүл дэх зан төлөв нь нийгмийг тодорхойлдог. Эргээд нийгэм нь гэр бүлийнхээ зан төлөвт нөлөөлдөг. Цөм /nuclear/ буюу аав ээж, хүүхдүүдээс бүрдсэн гэр бүл нь өргөжсөн гэр бүл буюу аав ээж, эмээ өвөө, үр хүүхэд, хамаатан саднуудаас бүрдсэн гэр бүлээс илүүтэй индивидуалист байдлын шалтгаан болон нөлөө нь болж өгдөг. Монголчууд өргөжсөн гэр бүлийн дотор төлөвшсөөр ирсэн.

Хүн ажлын болон ажлын бус аль ч орчиндоо ижил зан төлөвтэй байдаг гэж үздэг. Тухайн нийгэмд зонхилж буй хэм хэмжээ нь тухайн хүн болон түүний ажилладаг байгууллага хоорондын харилцаанд хүчтэй нөлөөлнө. Хамтач соёлтой нөхцөлд байгууллагын гишүүд нь сэтгэлзүйн хувьд ихээхэн хамааралтай байдаг. Монголчуудын хувьд өнөө үед гэр бүл, ойр дотно хүмүүсийн хүрээнд коллективист нийгмийн шинжүүд маш хүчтэй илэрч байгаа ч бусад хүрээнд тухайлбал ажлын орчинд илүү индивидуалист үйл хөдлөлүүд ихээхэн ажиглагдаж байна. Үүний учрыг эрдэмтэд монголчуудын хувьд нийгмийн доторх бүлгүүд нь өөрөө бусад соёлоос өвөрмөц байсантай холбоотой гэж үзэх нь бий. Энэ нь суурьшмал иргэншил, өнөө цагийн аж ахуй эрхлэлтийн нөхцөл байдалд биеэ даасан байдал ажиглагдаж буйн шалтгаан гэж үзэх нь бий.

Мөн дараахь хамаарлуудыг эрдэмтэд тодорхойлсон нь соёлын хэмжүүрийг тодорхойлоход тусална. Үүнд: индивидуализм нь баялагийн хэмжээтэй хүчтэй хамааралтай. Баялагийн хэмжээ багатай орнуудад хамтач нийгэм ажиглагддаг байна. Цаг уур индивидуалист байдалд нөлөөлж байна. Дулаан уур амьсгалтай орнуудад нийгэм нь илүү индивидуалист, хүйтэн сэрүүн уур амьсгалтай орнуудад илүү хамтач нийгэм ажиглагддаг. Дээрх нөхцөлүүд нь монголчуудын бие хүн болон нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцааг тодорхойлоход чиг болж өгнө.

		<p>Улс төр, оюун санаа, шашны хувьд хамтач нийгэмд хамт олны ашиг сонирхол хувь хүнийхээс дээгүүр, хамтын сонирхол нь эдийн засгийн шинжтэй, нийтийн ашиг сонирхол нь хувийн амьдралд халдах боломжтой, үзэл бодол, санал нь бүлгийн гишүүдийн оролцоотойгоор урьдчилан тодорхойлогдсон байдаг байна. Мөн улс төрийн эрх мэдэл тэнцвэргүй, нийгэм ангийн тогтолцоо хүчтэй, эдийн үасгийн секторуудын хувьд баялагын ялгаа их байдаг байна. Уламжлал болон шашнаасаа хамаараад хууль, эрхийн асуудал бүлгүүдийн хувьд ялгаатай, шашин дотоодын бүлгүүдийн зөрчилд хүчтэй нөлөөтэй, уламжлалаа дагасан байдал, хамтын ашиг сонирхлоос хувь хүнийхийг дээгүүрт тавихыг нүгэл гэж үздэг, хамтын эсвэл тухайлсан ашиг сонирхолтой холбож чадахгүйгээс эдийн засгийн тохиромжгүй онолуудыг импортлодог зэргээр хамтач соёлтой нийгэм индивидуалист соёлоос ялгардаг байна. Тэгвэл дээрх ялгаануудын зарим нь өнөөгийн нийгэмд илэрдэг хэдий ч нилээд нь илэрдэггүй. Социалист нийгэм байгуулах явцад тогтоосон хамтач хэм хэмжээнүүд 1990-ээд оноос шилжин орсон угаас индивидуал шинжтэй онолд суурилсан эдийн засгийн тогтолцоо руу орсонтой холбоотойгоор өөрчлөгдөв. Мөн гэр бүл судлаачид өнөө цагт мөн л гэр бүлийн бүтцэд өөрчлөлт орж байгаа тухайд хэлэлцэж байна. Түүнээс гадна объектив болон субъектив нөхцөл байдалд монголчуудын хамтач байх эсвэл индивидуалист шинж ялгаатай илэрдэг тухай эрдэмтэд тайлбарлаж байна. Энэ мэтээр бид хэр хамтач вэ гэдэг дээр ялгаатай үзэл бодлууд гарч ирж байна.</p> <p>Түүхэн нөхцөл байдлууд болон байгал цаг уур, хүн амзүйн хүчин зүйлс төдийгүй монголчуудын сэтгэлгээний онцлог зэргээс хамааран өнөө цаг үед бид ямар үнэт зүйлтэй байгаад байна вэ? Бидний хүсүүштэй үнэт зүйл юу вэ гэдгийг судлах, тодорхойлох шаардлага гарч ирж байна.</p>
2	Онолын хэсэг	<p>Тухайн нийгэмд зонхилж буй бие хүн болон хамт олон буюу нэгдмэл бүлгийн хоорондын харилцааг тайлбарлана. Энэ нь хүмүүс хамтаа хэрхэн амьдрах арга замд тусгалаа олно. Тухайлбал цөм гэр бүл, өргөтгөсөн гэр бүл, эсвэл овог отгоороо амьдрах бөгөөд үнэт зүйл, үйл хөдлөлийн урьдач нөхцөл болдог. Зарим соёлын хувьд индивидуалист байх нь сайн зүйл бөгөөд сайн сайхан байдлын эх үндэс болно гэж үздэг бол бусад соёлд энэ нь харш зүйл.</p> <p>Зарим амьтад сүргээр амьдардаг байхад бар мэт зарим амьтад ганцаар амьдардаг. Хүн эргэлзээгүйгээр сүргийн сэтгэлгээтэй амьтан хэдий ч хүний нийгэмд сүргийн сэтгэлгээний түвшин нь өөр өөр. Иймээс нийгмүүдийн хоорондын ялгааны суурь хэмжүүр нь бие хүн болон бүлгийн хоорондын харилцаа юм (Hofstede, 2001).</p> <p>Эрдэмтэн Hofstede Хүмүүс зөвхөн өөрийгөө болон өөрийн гэр бүлээ тойлон халамжилдаг эсвэл өөрөө гишүүн нь болох бүлэг хүмүүстээ ч үнэнч байж халамжлан тойлдог хэр хэмжээгээр хамтач эсвэл индивидуалист нийгэм эсэхийг тодорхойлжээ. Тэрээр хувь хүмүүсийн хоорондын холбоо гээгдсэн, зөвхөн өөрийгөө болон шууд харьяалах гэр бүлээ л гэх нийгмийг индивидуалист нийгэм гэж үзнэ. Харин гэр бүлээсээ гадна бусад өөрийн харьяалдаг бүлэгтээ хүчтэй нэгдэж амьдралын явцдаа тэднийгээ хамгаалах, үнэнч байх хэм хэмжээ тогтсон бол коллективист нийгэм гэж үзжээ.</p>

3	Шинж тэмдэгүүд	Hofstede хамтач болон индивидуалист соёл бүхий нийгмүүдэд зонхилох хэм хэмжээг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:	
		Хамтач соёл	Индивидуалист соёл
		Эцэг эх, хамаатнууд, бүлгийн гишүүдтэйгээ хамт юм уу ойр амьдардаг	Гэр бүл эцэг эх, хүүхдүүдээс л бүрддэг
		Бусдыг бүлэгт хамаарах болон бүлгээс гадуур гэж ангилдаг	Бусдыг индивидуал байдлаар ангилдаг
		Эцэг эхчүүд амьдралын турш нь хамгаалдаг	Хүүхдүүд аль болох хурдан биеэ даах ёстой гэж үздэг
		Гэр бүлийн хүчтэй холбоо байнгын холбоо харилцаа	Гэр бүлийн холбоо сул, цөөн харилцаа холбоо
		Гэр бүл салалт цөөн	Гэр бүл салалт их
		Хүүхдүүдэд “Бид” гэдэг сэтгэлгээ суудаг	Хүүхдүүдэд “Би” гэсэн сэтгэлгээ суудаг
		Ахмад хамаатнуудаа асран өвөг дээдсээ бишрэн хүндэтгэдэг	Ахмад хамаатнууд өөрсдийгөө халамжлах бөгөөд өвөг дээдсээ сайн мэдэхгүй гэдгээр хамаагүй байдаг
		Хүүхэдгүй гэрлэлт бүрэн дүүрэн биш	Хүүхэдгүй гэрлэлт хүлээн зөвшөөрөх зүйл
		Ээж нар нь хөгшрөхөөрөө хүүхдүүдтэйгээ амьдарна гэсэн найдвартай байдаг	Ээж нар нь хөгшрөхөөрөө тусдаа амьдрана гэсэн хүлээлттэй байдаг
		Бизнес эрхлэгчид эцэг эхтэйгээ хамт амьдардаг	Бизнес эрхлэгчид тусдаа амьдардаг
		Үргэлж ганцаараа байдаг хүн гэж ер үгүй	Ганцаараа байх явдал элбэг
		Санаа бодлоо бүлгээрээ тодорхойлдог	Хувь хүний санаа бодлыг хүлээн зөвшөөрдөг
		Хамаатнуудынхаа өмнө санхүүгийн болон ёслолын асуудлаар үүрэг хүлээдэг	Хамаатнууд санхүүгийн хувьд бие даасан байдалтай байдаг бөгөөд гэр бүлийн ёслол цөөн
		Уулзалдахдаа хэлэх албагүй	Зочлохдоо урьдчилж хэлэх ёстой
		Гэрлэх хосоо сонгох шалгуур: нас, эд баялаг, хөдөлмөрч байдал гэх мэт	Гэрлэх хосоо сонгох шалгуур тодорхой биш
		Гэрлэлтийг зохицуулж болно	Гэрлэлт хайр сэтгэл дээр үндэслэдэг
		<i>Сургууль</i>	
		Багш нар сурагчтайгаа бүлэг гэдэг талаасаа холбоотой байдаг	Багш нар сурагчидтайгаа индивидуал байдлаар холбогддог
Сурагчдын хувийн санаачлага дэмжигддэггүй	Сурагчдын хувийн санаачлага дэмжигддэг		
Зохицол, нүүр тулах байдал ангид байдаг	Сурагч өөрийгөө хүндлүүлэх ёстой		
Сургуулийн сурагч уламжлалыг дагах ёстой	Сургуулийн сурагч орчин үеийн үзэл бодолтой байх ёстой		

Сурагчдын идэвхтэй үйлдэл аятай бус	Сурагчдын өөрийгөө хүндэтгэх нь сургалтад сайн
Боловсролын зорилго нь яаж хийхэд сургах явдал	Боловсролын зорилго нь хэрхэн суралцахад сургах явдал
Диплом нь өндөр статус бүхий бүлэгт орох боломж олгоно	Диплом нь эдийн засгийн хувьд эд баялаг болон өөрийгөө хүндэтгэх байдлыг нэмэгдүүлнэ
<i>Ажил төрлийн хувьд</i>	
Ажилчид хамрагдаж байгаа бүлгийнхээ төлөө ажиллана	Ажилчид өөрийнхөө төлөө ажиллана
Ажилд авах болон урамшууллын талаархи шийдвэрт хамт олныг бодолцоно.	Ажилд авах болон урамшууллын талаар гаргах шийдвэр зөвхөн чадвар болон дүрэм журманд үндэслэнэ.
Ажилтан ажил олгогч хоёрын хоорондын харилцаа гэр бүлийн холбоотой адил ёс суртахуун дээр үндэслэнэ	Ажилтан ажил олгогч хоёрын харилцаа “хөдөлмөрийн зах зээл” дээрх бизнесийн холбоон дээр үндэслэнэ
Ажилтнууд бүлгээрээ ажиллахдаа сайн	Ажилтнууд индивидуал байдлаараа ажиллахдаа сайн
Сургалт хамт олонд чиглэсэн байвал үр дүнтэй	Сургалт хувь хүнд чиглэсэн байвал үр дүнтэй
Найзыгаа бусдаас илүү гэж тооцох явдал энгийн үзэгдэл	Найзыгаа бусдаас илүү гэж тооцох явдал ах дүүсэрхэг явдалд тооцогддог бөгөөд ёс зүйд үд нийцнэ гэж үздэг
Бизнес үүрэг даалгавар, компаниас илүү хувь хүний хоорондын харилцаа зонхилдог	Бизнес хувь хүний харилцаанаас илүү үүрэг даалгавар зонхилдог
Хамт олны шийдвэрт итгэж найддаг	Хувь хүний шийдвэрүүдэд итгэж найддаг
Ажилтнууд болон менежерүүд багийн ажлын тайлан гаргадаг	Ажилтан болон менежерүүд хувь хүний ажлын тайланг гаргадаг
Менежмент бол бүлгийн удирдлага гэсэн үг	Менежмент бол хувь хүний удирдлага гэсэн үг
Ажилтнуудыг нэг гэр бүлд байгаа мэтээр үздэг	Ажилтнуудыг хувь хүн гэдэг байдлаар ханддаг
Ажлын гүйцэтгэлийг шууд мэдээлэх нь зохицолд аюул учруулна	Ажлын гүйцэтгэлийг шууд мэдээлэх нь хөдөлмөрийн бүтээмжийг өсгөнө
<i>Хэрэглэгчдийн зан төлөв</i>	
Орон сууцанд амьдардаг	Хувийн цэцэрлэг бүхий өөрийн хаусанд амьдардаг
Хүмүүстэй амьдардаг	Муур эсвэл нохой гэх мэтийн амьтантай амьдардаг
Гэр оронтойгоо холбоотой ажилд найз нарынхаа туслалцааг авдаг	Гэр орныхоо ажлыг өөрөө хийж гүйцэтгэдэг

		<p>Бусадтай хамаарал бүхий амьдралын дүр төрхтэй</p> <p>Ном бага уншдаг, гэртээ компьютер бага хэрэглэдэг, телевиз илүүтэй үздэг</p> <p>Нийгмийн сүлжээ нь мэдээллийн эх үүсвэр болдог</p>	<p>Өөртөө түшиглэсэн амьдралын дүр төрхтэй</p> <p>Ном унших, компьютер хэрэглэх нь их</p> <p>Мэдээллийн хэрэгсэл мэдээллийн гол эхсурвалж болдог</p>
		<p>Дээрх хэм хэмжээ тухайн нийгэмд нэг бүрчлэн илрэх албагүй. Гэсэн хэдий ч дээрх хэм хэмжээ монголчуудын хувьд голчлон илэрдэг.</p> <p>Мөн дараахь хамаарлуудыг эрдэмтэд тодорхойлсон нь соёлын хэмжүүрийг тодорхойлоход тусална. Үүнд: индивидуализм нь баялагийн хэмжээтэй хүчтэй хамааралтай. Баялагийн хэмжээ багатай орнуудад хамтач нийгэм ажиглагддаг байна. Цаг уур индивидуалист байдалд нөлөөлж байна. Дулаан уур амьсгалтай орнуудад нийгэм нь илүү индивидуалист, хүйтэн сэрүүн уур амьсгалтай орнуудад илүү хамтач нийгэм ажиглагддаг. Дээрх нөхцөлүүд нь монголчуудын бие хүн болон нийгмийн бүлгүүдийн хоорондын харилцааг тодорхойлоход чиг болж өгнө.</p> <p>Улс төр, оюун санаа, шашны хувьд хамтач нийгэмд хамт олны ашиг сонирхол хувь хүнийхээс дээгүүр, хамтын сонирхол нь эдийн засгийн шинжтэй, нийтийн ашиг сонирхол нь хувийн амьдралд халдах боломжтой, үзэл бодол, санал нь бүлгийн гишүүдийн оролцоотойгоор урьдчилан тодорхойлогдсон байдаг байна. Мөн улс төрийн эрх мэдэл тэнцвэргүй, нийгэм ангийн тогтолцоо хүчтэй, эдийн үасгийн секторуудын хувьд баялагын ялгаа их байдаг байна. Уламжлал болон шашнаасаа хамаараад хууль, эрхийн асуудал бүлгүүдийн хувьд ялгаатай, шашин дотоодын бүлгүүдийн зөрчилд хүчтэй нөлөөтэй, уламжлалаа дагасан байдал, хамтын ашиг сонирхлоос хувь хүнийхийг дээгүүрт тавихыг нүгэл гэж үздэг, хамтын эсвэл тухайлсан ашиг сонирхолтой холбож чадахгүйгээс эдийн засгийн тохиромжгүй онолуудыг импортолдог зэргээр хамтач соёлтой нийгэм индивидуалист соёлоос ялгардаг байна.</p>	
<p>4</p>	<p>Асуултууд – VSM2013</p>	<p>Бие даасан гэдэг нь хамтачийн эсрэг байдал. Тэрээр хувь хүмүүсийн хоорондын холбоо гээгдсэн, зөвхөн өөрийгөө болон шууд харьяалах гэр бүлээ л гэх нийгмийг индивидуалист нийгэм гэж үзнэ. Харин хамтач нийгэмд гэр бүлээсээ гадна бусад өөрийн харьяалдаг бүлэгтэй хүчтэй нэгдэж амьдралын явцдаа тэднийгээ хамгаалах, үнэнч байх хэм хэмжээ тогтсон байна.</p> <p>Уг индексийг дараах байдлаар тооцно.</p> $IDV = 35(m04 - m01) + 35(m09 - m06) + C(ic)$ <p>m01 гэдэг нь асуулт нэгийн дундаж утга.</p> $IDV = 35(1.7 - 1.99) + 35(2.4 - 1.74) + 35 = 47.95$ <p>Индекс нь ерөнхийдөө 100 хүртэл хэмжигдэнэ. Индекс өндөр гарах нь ихээхэн бие даасан, бага гарах нь хамтач байдлыг харуулна. Тогтмол тоо нь C(ic) түүврээс хамаарна.</p>	

дараах асуултуудад хэрхэн идиал байдлаар хандаж байна вэ гэдгээр нь бие даасан эсвэл хамтач байдлыг тодорхойлов.

Асуулт 1. Хувийн болон гэр бүлийн өмьдралд хангалттай цаг хугацаа зарцуулдаг байх.


Асуулт 4. Ажлын аюулгүй байдлыг хангадаг байх

Асуулт 6. Сонирхдог ажлаа хийдэг байх

Асуулт.9 Өөрийн гэр бүл найз нөхөддөө хүндлэгдсэн ажилтай байх

5 Судалгааны үр дүн - асуулга


Хувийн болон гэр бүлийн амьдралд хангалттай цаг хугацаа гаргадаг байх



Хувийн болон гэр бүлийн амьдралд хангалттай цаг хугацаа зарцуулдаг байх

Хариулт	Давтамж	Эзлэх хувь
Дээд зэргийн чухал	1368	32.5
Маш чухал	1682	40
Нилээд чухал	996	23.7
Бага зэрэг чухал	141	3.4
Чухал биш	19	0.5
Нийт	4207	100
Mean	1.99	
Mode	2	


Ажлын аюулгүй байдлыг хангадаг байх



Ажлын аюулгүй байдлыг хангадаг байх

Хариулт	Давтамж	Эзлэх хувь
Дээд зэргийн чухал	1973	46.9
Маш чухал	1610	38.3
Нилээд чухал	536	12.7
Бага зэрэг чухал	72	1.7
Чухал биш	14	0.3
Нийт	4205	100
Mean	1.7	
Mode	1	

Сонирхдог ажлаа хийдэг байх



Сонирхдог ажлаа хийдэг байх

Хариулт	Давтамж	Эзлэх хувь
Дээд зэргийн чухал	1948	46.3
Маш чухал	1562	37.1
Нилээд чухал	563	13.4
Бага зэрэг чухал	111	2.6
Чухал биш	25	0.6
Нийт	4209	100
Mean	1.74	
Mode	1.00	

Өөрийн гэр бүл найз нөхөддөө хүндлэгдсэн ажилтай байх



Өөрийн гэр бүл найз нөхөддөө хүндлэгдсэн ажилтай байх

Хариулт	Давтамж	Эзлэх хувь
Дээд зэргийн чухал	823	19.6
Маш чухал	1589	37.8
Нилээд чухал	1203	28.6
Бага зэрэг чухал	485	11.5
Чухал биш	108	2.6
Нийт	4208	100
Mean	2.4	
Mode	2	

6 Судалгааны үр дүн - ярилцлага

Судлаачдын үзэл бодол:

П.Очирбат: Монголын үнэт зүйл иргэншлийн хэлбэрээс болоод нэг янз байсан. Төвлөрөл, суурьшлын элемент ороод ирэхээр агуулга хэлбэр нь хувирч байна. Өнөөгийн үнэт зүйлийг өмнөх үетэй харьцуулахад их өөр юм. Нүүдлийн соёл иргэншлийн үед хүмүүс байгалийн нөхцөлтэй уялдаад бие даасан шийдвэр гаргаж, амьдралын хэв шинжээ орчинтой холбож, ганцаарчилсан төлөвтэй байлаа. Бодгаль аж ахуйгаа авч явах шийдвэр гаргах чадвар “өөрөөс” нь их хамаарч байв. Суурин соёл иргэншлийн үед хамтрах, хамтач, бусадтай нийцэх, зөвлөлдөх (цаг уурын мэдээгээ ч хүнээс авна) зүйл бий болсон байна. Нэгэнт бие биеэс зайдуу амьдарч байсан хүмүүст мэдээлэл олж авах арга их өвөрмөц, бие биедээ тусархуу, зочломтгой, хүндлэх зан чанартай байв. Нөхөрсөг, дотно, олзуурхуу, өргөн хүрээтэй яриа хөөрөө хийдэг, өвөлжөө бууцандаа буугаад үр хүүхдэдээ үлгэр домгоо ярьж өгдөг соёлтой байлаа. Суурин соёл иргэншлтэй болоод ирэхээр хүний мөрөөсөл болсон, зочломтгой чанар гээгдээд хувиа хичээсэн, хүнд хандах хүн чанар их бүрхэг болжээ. Нийгэм ойртоод, бөөгнөлөө гэтэл бүр ч холдсон мэт. Хүний өөрийн гэлтгүй хэлж сургадаг байсан нь алдагдсан байна. Ер нь өөриймсөг бус болжээ (Монголын ирээдүй өөриймсөг бус болж байна). Суурин соёл нь монгол зан заншлыг

эвдсэн, хувиа хичээсэн соёл байна. Гэвч монголчуудын зан суртахуунд орж буй өөрчлөлт суурин соёлынх юм уу гэхээр бас үгүй (Хөршийнхөн нь хүүхдээ зодоход хэлж дуулгадаг). Төрмөл шинж нь нүүдэл, олдмол шинж нь суурин юм. Унаган, төрмөл соёл нь амьдрах чадвар өндөр, генээр дамждаг, хадгалагдаж л байдаг. Олдмол соёлы дуурайж байгаа учир өнгөц суудаг. Үүнээс үүдэн зохиомол, хиймэл, буруу ойлгосон хандлага (хувь хүний орчны нөлөөллийг өртөө тусгах, нийгмийн нөлөөллийг өөртөө тусгах) гарч байна. Ямар нэг хэмжээгээр ялгаа байна. Нийгэмших дээр л унаган шинжээ алдаад байна. Хүний мөс муу талруугаа өөрчлөгдөж байна. Юу нөлөөлөөд байна вэ гэвэл суурин амьдрал нь орон зайн хязгаарлагдмал тул, хурдацтай тул, зохиомол орчин бүрдсэн унаган шинжинд нь тохирохгүй байгаа тул уурлаж, цухалдаж байна. Өөртөө л тав тухаа олж явдаг байсан хүмүүс шүү дээ.

Орон зай уужуу байхад сэтгэл уужуу байхад сэтгэл уужуу, амьдралд хандах хандлага бодитой. Хөдөлгөөн, дуу шуугиан, орон зайн хязгаарлалт монголчуудыг бухимдуу болгож байна. Гэтэл хотод төрсөн хүн, хөдөө ч явж үзээгүй хүн бий шүү дээ гэх нь бий. Энд амьдралын үнэ цэнийн талаарх асуудал гарч байна. Монголчууд эд хураадаггүй, хэрэглэдэг зүйлс ч нүсэр биш байжээ. Баабар хэлэхдээ морио унасан монгол тэр чигээрээ хөрөнгөтэйгээ явж байдаг саятан гэж хэлсэн нь бий. Суурин соёлд саятан нь түүнийгээ эд эсвэл хөрөнгө болгочихсон, хадгалчихсан байдаг.

Ер нь, монголчуудад шунал байдаггүй. Шунал хүнийг эвддэг. Хуримтлах, хадгалах, бөөгнүүлэх шуналын сэдэл, баян байх гэсэн сэтгэлгээ, өмчийн сэтгэхүйнээс болж ааш зан эвдэрч байна. Өмчийн сэтгэлгээ нүүдэлчдэд тогтохгүй байх шиг байна. Эд хөрөнгө ба сэтгэл гэсэн хоёр зүйлийн тэнцвэрийг олбол болох юм шиг. Өмчийн сэтгэлгээ хувиа хичээсэн шинжийг нэмж байна. Нүүдэлчдийн хүнээ гэх асар том асар том үнэ цэн байдаг. Дээд үнэ цэнт зүйлийн нэг.

Одоо бид ямар нэгэн байдлаар суурин амьдарч байна. Монголчуудад байх ёстой үнэ цэнт зүйлээ алдаж, алдсан хэрээрээ нөхөж чадахгүй байна. Иймээс хүний мөсгүй болжээ. Удам судрыг харах гэх ойлголт бий. Эцэг эхийн нэрийг бодох, ясыг өндөлзүүлэхгүй байх гэх ойлголт ч үүнээс гарч ирнэ. Удам судраа муу хэлүүлэхгүйн тулд (цаашлаад монголын нэрийг хамгаалах) хичээдэг байв. Одоо бум бужигнасан энэ орчинд уламжлал бүдгэрч, өөрөө л болж байвал болоо гэсэн сэтгэлээр хэнээс ч , юунаас ч хамааралгүй болж, хүн дүрсээ алдаж байна. Хүмүүжил, ухамсар, соёлоор суусан байх цадиг алга болжээ.

Академич Төмөртоогоо: Үан заншилаа харах юм бол гэр, хотлоороо амь нэг, хамтач байдалтай. Гэтэл социалны хувьд нийгмийн бүлэг бүрдүүлж байсан түүх бага. Цэрэг дайны үед хүчээр нэгтгэж байсан. Багаар ажиллах чадвар дутмаг. Монголд ажилтнууд байгууллагатай үнэнч биш, ажлаас боломжтой болуут гардаг. Европчууд монголчуудыг ихээхэн бие даасан гэж үзэх нь

	бий. Монголчуудын сэтгэлгээ ихээхэн бохирдсон. Моонголчуудын энэ байдал удаан үргэлжилбэл 15-20 жилийн дараахыг төсөөлөхөд маш хэцүү.
--	---

2. MASCULINITY vs FEMINITY

№	Masculinity	
1	Судлах үндэслэл	<p>Монголын газар нутгийн байршил, байгаль, цаг уурын онцлогоос харвал эрс тэс уур амьсгалтай учир феминин давамгайлж болохуйц байсан хэдий ч олон мянган жилийн зохилдолгоогоор бий болгосон нүүдэллэн аж төрөх ёсны хэв шинж нь эрэгтэйчүүд гол шийдвэрийг гаргаж, гадаад аж ахуйг эрхлэх, эмэгтэйчүүд дотоод үйлдвэрлэлийг голлон эрхлэх хэдий ч бүх ажил үйл уялдаа холбоотой байж байж оршин тогтнох тул жендерт маскулин шинж давамгайлах хандлагатай байжээ. Харин 1940-өөд оноос идэвхтэй суурьшиж эхэлснээр 2014 оны байдлаар нийт хүн амын 43.8% нь Улаанбаатар хотод амьдарч байна. Суурин болсон энэ үед ч амжилт ололтыг эрхэмлэж, материаллаг зүйлсийг хүсэмжилж, маскулин шинж давамгайлах хандлагатай байна. Сүүлийн жилүүдэд ялангуяа залуучууд нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа явуулж, олон нийтийг уриалж байгаа нь бий болгохыг хүсдэг үнэт зүйл феминин байгааг хариулж байна. Гэвч хүсүүштэй үнэт зүйл нь ямар байх нь бидэнд чухал болохыг судлах хэрэгцээ бий болж байна.</p>
2	Онолын хэсэг	<p>Хэрэв төрөх, үхэх нь амьдралын 1 дэх хууль гэж үзвэл бүх дээд амьтдын хувьд эр, эм байх нь амьдралын 2 дахь хууль гэж хэлж болох юм. Эрт үеэс хүн төрөлхтний нийгмийн амьдралын зохиолдолгоо бий болоход олон хүчин зүйл нөлөөлсөн хэдий ч соёлын хэм хэмжээний гол цөм нь хүйс байсан гэж хэлж болно.</p> <p>Хүйсийн абсолют утгаар эмэгтэйчүүд хүүхдээ тээдэг, эрэгтэйчүүд хүүхдийг бий болгодог, статистик утгаар эрэгтэйчүүд илүү өндөр, хүчтэй (гэвч эрчүүдээс илүү өндөр болон хүчтэй эмэгтэйчүүд бий), эмэгтэйчүүд илүү эв дүйтэй байдаг байна. Харин нийгмийн хүйс гэх жендерийн хувьд соёлын хэм хэмжээ, уламжлалаар тогтоогддог бөгөөд статистик утгаар эрэгтэйчүүд хүчтэй, өрсөлдөмхий, гэсвэр хатуужилтай, эрэмгий, эмэгтэйчүүд зөөлөн, бусдыг халамжилдаг байна. Энэхүү эрэгтэйчүүдийн өөртөө итгэлтэй, тууштай байдал, эмэгтэйчүүдийн бусдыг халамжилдаг байдал наанадаж улс төр болон эдийн засгийн салбарт эрчүүд давамгайлах хандлага, гэр бүл болон өргөжүүлсэн гэр бүл дэх хүсийн эрх тэгш байдлын ялгааг бий болгодог байна. Гэвч жендерийн эдгээр ерөнхий хандлага нь абсолют биш учир маскулин болон феминин шинжтэй улс орон гэх тодорхойлолт бий болдог. Ажил үүргийн хувьд авч үзэхэд удирдах албан тушаалын эмэгтэйчүүд тухайн албан тушаалын эрэгтэйгээс илүү маскулин байдаг бөгөөд албан тушаалын зэргэлэл харгалзахгүйгээр нас ахих тусам маскулин шинж буурдаг байна.</p> <p>Газарзүй, байгаль орчны онцлогийн хувьд хэт халуун, хэт хүйтэн орнуудыг бодвол дулаан уур амьсгалтай оронд илүү өндөр байдгаас</p>

		гадна түүнээс гадна түүхэн талаас эрэгтэйчүүд дайн тулаан, ан гөрөөнд явж, гэрээс холдох тусам эмэгтэйчүүдийг өрх гэрээ авч явах хариуцлага, шаардлага нэмэгдэж, нийгэм маскулин шинжтэй болж эхлэх хандлагатай байжээ.	
3	Шинж тэмдэгүүд	Нийгмийн хэм хэмжээ	
		Low MAS	High MAS
		Харилцаанд суурилсан.	Бие хүнд суурилсан.
		Амьдралын чанар болон хүмүүс чухал.	Мөнгө болон эд зүйлс чухал.
		Өөрийгөө хэн бэ гэдэгт санаа зовнидог.	Өөрийгөө юу хийсэнд санаа зовнидог.
		Амьдрахын төлөө ажилладаг.	Ажиллахын төлөө амьдардаг.
		Нийгмийн үүрэг болон зан суртахууны ялгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүст бага.	Нийгмийн үүрэг болон зан суртахууны ялгаа эрэгтэй, эмэгтэй хүмүүст өндөр.
		Эрэгтэй эмэгтэй ялгалгүй ажлын гүйцэтгэл болон харилцаа холбоонд адил анхаарна.	Эрэгтэйчүүд ажлын гүйцэтгэлд илүү анхаарна, эмэгтэйчүүд харилцаа холбоонд анхаарна.
		Эрэгтэй болон эмэгтэй хүмүүс даруу төлөв байна.	Эрэгтэйчүүд заавал, эмэгтэйчүүд зарим үед амжилт ололтын төлөө явдаг байна.
		Сул доройг таашаадаг.	Хүч чадалтайг таашаадаг.
		Бага ба удаан бол сайн.	Их ба том байвал сайн.
		Гэр бүлд	
		Low MAS	High MAS
		Хүүхдүүдийн дунд жендерийн ялгаа сул.	Хүүхдүүдийн дунд жендерийн ялгаа их.
		Үүрэг ролийн загвар энгийн: Аав ээж хоёр хоёулаа бодит байдал болон мэдрэмжээрээ шийддэг.	Үүрэг ролийн загвар ялгаатай: Аав нь бодит байдлаар ээж нь мэдрэмжээрээ шийддэг.
		Охид хөвгүүд ялгаагүй уйлж болно гэхдээ зодолдож болохгүй.	Охид уйлж болно, хөвгүүд бол үгүй, хөвгүүд бусдын өөдөөс нь зодолдож болно охид болохгүй.
		Охид хөвгүүд аль аль нь даруу байдалд суралцах ёстой.	Охид хөвгүүд амбицтай байж сурах хэрэгтэй.
		Эсрэг хүйсний хүн нь хүүхдэд болон амьдралын чанар чансаанд дуртай байна.	Эсрэг хүйсний хүн нь ажилдаа амжилттай байх ёстой.
		Гэр орон болон гэр бүлийн тухайд эерэг мэдрэмжтэй.	Гэр орны амьдралд нэг их сэтгэл ханамж авдаггүй.
		Хүүхэд түрэмгий биш.	Хүүхэд түрэмгий байдал гаргаж мэднэ.
		Найз нөхөд болон танил чухал.	Гэр бүл чухал
		Эцэг эх хүүхдүүдийнхээ хайр хүндэтгэлийг олж авах ёстой.	Хүүхдүүд эцэг эхээ хайрлаж хүндэтгэх ёстой.
Гэрлэлгүйгээр хамт амьдрах нь их.	Дорхноо гэрлэх нь их.		
Гэр бүлийн талаархи төсөөлөл уян хатан .	Гэр бүлийн талаархи төсөөлөл уламжлалт байдалтай.		

Хосууд өөр өөрийн сонирхолтой.	Хосууд сонирхолоо хуваалцах ёстой.
Ээж нь хүүхдийнхээ тооны талаар шийдвэр гаргана.	Эцэг нь гэр бүлийнхээ хэмжээг шийднэ.
Сургууль дээр	
Low MAS	High MAS
Сурагчдын нийгэмдээ дасан зохицох явдал нь чухал.	Сурагчдын ажил гүйцэтгэх чадвар нь чухал.
Сургуульд амжилтгүй суралцах нь ялихгүй аюул.	Сургуульд амжилтгүй суралцах нь тун их аюул.
Тусгай шагналгүй.	Сайн сурагч болон багшийн шагналуудтай.
Дундаж оюутан бол хэм хэмжээ болж өгнө.	Сайн оюутан бол хэмхэмжээ болж өгнө.
Хүүхэд түрэмгий байдлаас зайлсхийдэг.	Хүүхэд өөдөөс нь тэмцэхэд суралцдаг.
Сурагч өөрийн проблемийг нэг их айхтар авч үздэггүй.	Сурагч өөрийн проблемийг нилээн айхтар авч үздэг.
Багш охид хөвгүүдэд адилхан анхаарал тавьдаг.	Багш нар хөвгүүдэд илүү анхаарал тавьдаг.
Охид хөвгүүд ижил хичээл үздэг.	Охид хөвгүүд өөр өөр хичээл үздэг.
Жендерийн хувьд	
Low MAS	High MAS
Жендерийн хувьд соёлын ялгаа бага.	Жендерийн хувьд соёлын ялгаа их.
Мэргэжлийн болон техникийн ажлын хувьд эмэгтэйчүүдийн эзлэх хувь их.	Мэргэжлийн болон техникийн ажлын хувьд эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага.
Эмэгтэйчүүдийн уламжлалт бус үүрэг роль бий болсон.	Эмэгтэйчүүдийн уламжлалт үүрэг роль
Жендерийн талаарх хэвшмэл ойлголт нь биологийн ялгаан дээр нь үндэслэсэн.	Жендерийн талаарх хэвшмэл ойлголт нь орон бүрт өөр.
Шинж чанар нь жендерийн хувьд бага ялгагдана.	Хариуцлага болон амбицтай байдал эрэгтэйчүүдэд, халамжлах болон аядуу тогтуун байдал нь эмэгтэйчүүдэд хамаатай гэж үздэг.
Эмэгтэйчүүдийн либералчлал гэдэг нь эмэгтэйчүүд гэр орон болон ажил дээрээ аль алинд нь адил тэнцүү байх ёстой гэсэн утгаар ойлгогдоно.	Эмэгтэйчүүдийн либералчлал гэдэг нь эмэгтэйчүүд урьд өмнө эрэгтэйчүүд л хийж байсан ажлыг хийхээр хүлээн зөвшөөрөгдөх ёстой гэсэн утгаар ойлгогдоно.
Хэрэглэгчийн зан төлөв	
Low MAS	High MAS
Худалдан авах шийдвэр болон худалдан авалтыг хамтрагчид хамтдаа хийнэ.	Эрэгтэйчүүд худалдан авах шийдвэр гаргаж, эмэгтэйчүүд худалдан авдаг.
Кофе чанагч тав тух бий болгохын тулд оршдог.	Шүүгчтэй кофе чанагч бага ашигладаг.
Гэрт хийсэн бүтээгдэхүүнийг илүүд үзнэ.	Бүтээгдэхүүнийг гэртээ хийх нь ховор.

Хэрэглэхийн тулд худалдаж авдаг.	Үзүүлэхийн тулд худалдаж авдаг.
Гадны бүтээгдэхүүнийг шохоорхох нь бага.	Гадны бүтээгдэхүүнийг илүүтэйгээр шохоорхдог.
Хөдөлгүүрийн хүч сайтай машин нийцэхгүй.	Хөдөлгүүрийн хүч сайтай машин нийцнэ.
Гэр бүлээрээ машинтай аялал хийж амрах.	Гэр бүлээрээ онгоцоор нисч аялал хийнэ.
Уран зохиолын ном илүү уншдаг.	Уран зохиолын биш ном илүү уншдаг.
Зар сурталчилгаанд итгэх нь бага.	Зар сурталчилгаанд итгэдэг.
Ажлын байранд	
Low MAS	High MAS
Ажилтнуудын хувьд харилцаа холбоо, ажиллах нөхцөл нь ажлын гол утга учир болдог.	Ажилтнуудын хувьд аюулгүй байдал, цалин урамшуулал, сонирхолтой байх нь ажлын гол утга учир болдог.
Эрх тэгш байдал, нэгдэл нягтрал, амьдралын чанарын төлөө санаа зовнидог.	Эд хөрөнгө, өрсөлдөөн, үзүүлэлтийн төлөө санаа зовнидог.
Удирдахуй нь аж ахуй эрхлэх юм.	Удирдахуй нь тоглолтын талбар.
Менежер нь бусад ажилтнуудтай адил ажилтан.	Менежер бол үлгэрлэгч.
Жендерийн ялгаа бага.	Жендерийн ялгаа өндөр.
Эмэгтэйчүүд эмэгтэй удирдагч сонгодог.	Эмэгтэйчүүд эрэгтэй удирдагч сонгодог.
Карьерийн амбиц эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдэд адил.	Карьерийн амбиц эрэгтэйчүүд зайлшгүй, эмэгтэйчүүдэд сонголтот зүйл байдаг.
Менежерүүд карьераас болж гэр бүлийнхнээсээ татгалзахад бэлэн биш.	Менежерүүд карьераас болж гэр бүлийнхнээсээ татгалзахад бэлэн.
Менежер эмэгтэй гэр бүлээ эхэнд тавьж, ажил үүргээ дараа нь тавина.	Менежер эмэгтэй ажил үүргээ эхэнд тавьж, гэр бүлээ дараа нь тавина.
Ажилд орохыг хүсэгч өөрийгөө дөвийгдөггүй.	Ажилд орохыг хүсэгч өөрийгөө дөвийгдөдөг.
Багийн ажлаар хүмүүжүүлэх.	Өрсөлдөөнөөр хүмүүжүүлэх.
Зөрчлийг асуудлыг шийдвэрлэх, зөвшилцөх, хэлэлцэх аргаар шийдвэрлэнэ.	Зөрчлийг үгүйсгэх, шилдэг нь дийлэх аргаар шийдвэрлэнэ.
Өвчтэй учир ажил таслах нь элбэг.	Өвчний бус шалтгаанаар ажил таслах нь элбэг.
Ажлын стресс бага.	Ажлын стресс их.
Жижиг компанид ажиллахыг илүүд үзнэ.	Том компанид ажиллахыг илүүд үзнэ.
Цөөн цаг ажиллахыг эрхэмлэнэ.	Өндөр цалинтай ажиллахыг эрхэмлэнэ.
Үйлчилгээний байгууллага, зөвлөгөө өгөх, гэр ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл,	Үйлдвэрлэл, үнийн өрсөлдөөн, хүнд үйлдвэрлэл, бодис үйлдвэрлэлд өрсөлдөөн их.


		биохимийн салбарт өрсөлдөөн их.	
		Улс төр дахь давуу эрх	
		Low MAS	High MAS
		Хамгаалдаг нийгэм – идеал.	Гүйцэтгэдэг нийгэм – идеал.
		Ядуу болон бичиг үсэг тайлагдаагүй хүмүүсийн эзлэх хувь бага.	Ядуу болон бичиг үсэг тайлагдаагүй хүмүүсийн эзлэх хувь өндөр.
		Тусламж хэрэгтэй нэгэн түүнийгээ авна.	Хүчтэй нэгэн дэмжлэг авна.
		Баячууд татвар төлж ядууст тусалдаг.	Ядуусын хувь заяа зөвхөн тэдэнд хамаатай.
		Хүлцэнгүй нийгэм	Шийтгэдэг нийгэм
		Цагаачдыг хүлээн зөвшөөрдөг.	Цагаачид дасан зохицох ёстой, үгүй бол буцах ёстой.
		Олон улсын зөрчилдөөнийг гэрээ хэлцэл, зөвшилцлөөр шийднэ.	Олон улсын зөрчилдөөнийг хүчээр эсвэл сөргөлдөөнөөр шийднэ.
		Байгаль орчноо хамгаалах нь нэн тэргүүний чухал зүйл юм.	Эдийн засгийн өсөлт нь нэн тэргүүний чухал зүйл юм.
		Биотехнологийн эрсдэлд нийгэм даяар санаа тавьдаг.	Биотехнологийн эрсдэлд нийгэм бага анхаардаг.
		Улс төрийн хэв шинж	
		Low MAS	High MAS
		Улс төрийн хэлэлцээр тайван, хүлээцтэй байдаг.	Улс төрийн хэлэлцээр ширүүн, сөргөлдөөнтэй байдаг.
		Сонгогчдын цөөнх нь төвийг баримталж, ихэнх нь тэгш байдлыг баримтлана.	Сонгогчдын цөөнх нь тэгш байдлыг баримталж, ихэнх нь төвийг баримтлана.
		Улс төрийн институт, тогтолцоонд эерэг хандлагатай байна.	Улс төрийн институт, тогтолцоонд сөрөг хандлагатай байна.
		Ядуу оронд авлига бага.	Ядуу оронд авлига их.
		Ажилчин ангид илүү тааламжтай нөхцөл бүрдсэн.	Ажилчин ангид илүү тааламжгүй нөхцөл бүрдсэн.
		Сайн дурын ажилд илүү их хамрагддаг.	Сайн дурын ажилд илүү бага хамрагддаг.
		Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд улс төрийн талаар адил, ижил хэмжээгээр хэлэлцдэг.	Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү улс төрийн талаар хэлэлцдэг.
		Засгийн газарт илүү олон сонгогдсон эмэгтэй улс төрч байдаг.	Засгийн газарт цөөн сонгогдсон эмэгтэй улс төрч байдаг.
4	Асуултууд – VSM2013	$MAS = 35(m05 - m03) + 35(m08 - m10) + C(mf)$ 3. Сайн гүйцэтгэлийг тань үнэлж сайшаадаг байх Дээд зэргийн чухал (1) = Маскулин 5. Хамт ажиллахад тааламжтай хүмүүстэй байх Дээд зэргийн чухал (1) = Феминин 8. Ажил тань таны хүссэн байршилд байх Дээд зэргийн чухал (1) = Феминин 10. Урамшуулал авах боломжтой байх Дээд зэргийн чухал (1) = Маскулин Маскулин асуултын хариултын дундаж өндөр байхаас илүүтэй феминин асуултад маскулин хариулах тусам индекс өндөр гарна.	

5 Судалгааны үр дүн - асуулга

Судалгааны үр дүнг 4214 оролцогчийн мэдээлэлд тулгуурлан гаргав.

Хүснэгт 2. Masculinity-ийн асуултад хариулсан байдал

	Дээд зэргийн чухал 1	2	3	4	Чухал биш 5
Асуулт 3	1445	1944	692	96	20
Асуулт 5	1414	1880	766	125	14
Асуулт 8	542	1148	1425	925	166
Асуулт 10	1018	1636	1148	334	59



Асуулт 3: Уг асуулт нь маскулин шинжийг илэрхийлэх асуулт бөгөөд оролцогчдын 80.7% нь дээд зэргийн чухал, маш чухал гэсэн хариултыг сонгожээ. Оролцогчдын хувьд ажил үүргээ гүйцэтгэсний дараа түүнийг үнэлүүлэх нь чухал болохыг илэрхийлсэн байгаа нь MAS өндөр орны ажлын байранд илэрдэг эд хөрөнгө, өрсөлдөөн, үзүүлэлтийн төлөө санаа зовнидог шинжтэй дүйж байна.

Монголчуудын хувьд бусдын амжилтаар бахархахаас илүү өрсөлдөж, өөрийгөө харуулах, бусдаас онцгойрох сэдэл ихтэйгээс гадна сайн дурын ажлыг ч өөрийгөө дөвийлгөхөд ашиглах тал бий.

Асуулт 5: Уг асуулт нь феминин шинжийг илэрхийлэх асуулт бөгөөд судалгаанд оролцогчдын 78.5% нь дээд зэргийн чухал, маш чухал гэсэн хариултыг сонгожээ. MAS бага оронд ажлын гол утга учир нь харилцаа холбоо байх бөгөөд, нэгдэл нягтрах, амьдралын чанарын төлөө санаа зовнидог байх бөгөөд асуултад хариулсан байдлаас феминин шинж давамгайлж ажиглагдаж байна.


Асуулт 8: Уг асуулт нь феминин шинжийг илэрхийлэх асуулт бөгөөд судалгаанд оролцогчдын 40.2% нь дээд зэргийн чухал, маш чухал гэсэн хариултыг сонгожээ. MAS бага оронд ажлын нөхцөл байдал нь амжилт ололт, цалин урамшууллаас өндөр тавигддаг байна. Оролцогчдын асуултад хариулсан байдал хэвийн тархалттай байгаа нь ажилдаа дур сонирхолтой бол

байршил хамаарахгүй ажлаа сонгох хандлагатай байгааг илтгэнэ.

Монголчуудын хувьд төвлөрсөн суурин газрын нутаг дэвсгэр харьцангуй бага учир хүссэн ажилдаа байршил харгалзахгүй ажиллах нөхцөл бүрэлдсэн байна.

Асуулт 10: Уг асуулт нь маскулин шинжийг илэрхийлэх асуулт бөгөөд оролцогчдын 63.3% нь дээд зэргийн чухал, маш чухал гэсэн хариултыг сонгожээ. MAS өндөр оронд байх өндөр цалинтай ажиллах, өрсөлдөөнөөр хүмүүжүүлэх, үзүүлэлт, гүйцэтгэлд анхаарал хандуулах шинжийг илэрхийлж байна. Монголчуудын хувьд сүүлийн 20 гаран жилийн хугацааны нийгмийн бүхий л хүрээлний өөрчлөлт монголчуудын хүсдэг үнэт зүйлийг өөрчилж байгааг оролцогчдын хариултаас харж болно. Нүүдэлчин амьдралд нэн чухал бус байх ашиг орлого, эд хөрөнгө, материаллаг баялгаас илүү “сэтгэлд өөг”, “хүний хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтдэг”, “бурмаар тэтгэхээр урмаар тэтгэдэг” хандлага өөрчлөгдөж байгаа нь ажиглагдаж байна.

Дүгнэлт: Асуултуудад хариулсан байдлыг дүгнэвэл 3 ба 10 дугаар асуултад маскулин шинж давамгайлсан, 5 дугаар асуултад феминин шинж давамгайлсан, харин 8 дугаар асуултад бага зэрэг феминин шинж давамгайлдснаар маскулин байдал бага зэрэг давамгайлч феминин шинж мөн адил байгааг хариулж байна.



Хүснэгт 3. Masculinity: Хариултуудын дундаж, медиан, моод

		Q3	Q5	Q8	Q10
N	Valid	4197	4199	4206	4195
	Missing	17	15	8	19
Mean		1.88	1.92	2.77	2.23
Median		2.00	2.00	3.00	2.00
Mode		2	2	3	2
Std. Deviation		.793	.813	1.055	.953

$$\begin{aligned}
 MAS &= 35(m05 - m03) + 35(m08 - m10) + C(mf) = \\
 &= 35(1.92 - 1.88) + 35(2.77 - 2.23) + C(mf) = \\
 &= 20.3 + C(mf) = 20.3 + 35 = 55.3
 \end{aligned}$$

6	Судалгааны үр дүн - ярилцлага	<p>Хэл шинжлэлийн ухааны доктор Д.Төмөртоогоо: Массыг төлөөлөн хэлж чадахаа байжээ. Өөрийгөө их магтдаг, эх оронч гэж цээжээ дэлддэг хэдий ч юугаараа бахархаж байгаагаа бид тодорхойлж чадахгүй байна. Монголд тэр бумтнууд байна гэж бахархаж байгаа ч тэд нийгмийн сайн сайхны төлөө хөрөнгө оруулалт хийх чадваргүй, санаачлагагүй, сэтгэлгүй байгаа нь хөдөө орон нутагт гараад байгаа түймэрт хандив өргөхгүй байгаагаар л харж болохоор байгаа юм. Гадны улс орнуудад амжилтын төлөө явж, ашиг орлого олдог ч хэзээ ч нийгмийн сайн сайхныг орхигдуулдаггүй бизнесийн байгууллагуудын хууль бий. Ядуу сэтгэлгээ гэх үү?</p> <p>Эдийн засгийн ухааны доктор П.Очирбат: Ер нь, монголчуудад шунал байдаггүй. Шунал хүнийг эвддэг. Хуримтлах, хадгалах, бөөгнүүлэх шуналын сэдэл, баян байх гэсэн сэтгэлгээ, өмчийн сэтгэхүйнээс болж ааш зан эвдэрч байна. Өмчийн сэтгэлгээ нүүдэлчдэд тогтохгүй байх шиг байна. Эд хөрөнгө ба сэтгэл гэсэн хоёр зүйлийн тэнцвэрийг олбол болох юм шиг. Өмчийн сэтгэлгэ хувиа хичээсэн шинжийг нэмж байна. Нүүдэлчдийн хүнээ гэх асар том асар том үнэ цэн байдаг. Дээд үнэ цэнт зүйлийн нэг. Одоо бид ямар нэгэн байдлаар суурин амьдарч байна. Монголчуудад байх ёстой үнэ цэнт зүйлээ алдаж, алдсан хэрээрээ нөхөж чадахгүй байна. Иймээс хүний мөсгүй болжээ.</p> <p>Удирдахуйн ухааны доктор Я.Бямбасүрэн: Монголд одоогоор жунглын хууль үйлчилж байна. Фиминин нийгэмтэй байх нь үр ашигтай. Гадны улс орнуудад төрийн бус байгууллагууд итгэл даахуйц байж, хамгийн гол нийгэмд чиглэсэн ажлыг хийдэг бол манайд уялдаа холбоотойгоор бүрэн хөгжиж чадаагүй л байна. Гэвч, феминин нийгэмтэй байх хүсэл эрмэлзлэл бий болж байна.</p> <p>Философийн ухааны доктор Б.Пүрэвсүрэн : Амжилт ололтод дуртай бөгөөд энэ нь мөхөж буй иргэншлийн шинж юм. Хэрэглээний сэтгэлгээ өндөр. Нийгмийн үйлчилгээ бүтэцчилэгдээгүй. Ер нь бодит жунглын хууль үйлчилдэг гэж хэлж болно.</p>
---	-------------------------------	---

3. УРТ ХУГАЦААНЫ ХАНДЛАГА (LONG-TERM ORIENTATION)


№	Монголчууд урт хугацаанд ханддаг уу, богино хугацааны хандлагатай юу? Өнөөдрөөрөө амьдарч байна уу, ирээдүйд хандсан хандлага их байна уу?																			
1	Судлах үндэслэл	Соёлын чиг хандлагаар нь богино хугацааны баримжаатай юу, урт хугацаанд чиглэдэг үү гэдгийг судлах нь удирдлага болон аливаа хэлэлцээр хийхэд чухал ач холбогдолтой байдаг. Аливаа улс орны хөгжлийн бодлого төлөвлөлтөнд энэхүү үзүүлэлт чухал нөлөөтэй бөгөөд удирдлагын хувьд анхаарах чухал үзүүлэлт болж байдаг.																		
2	Онолын хэсэг	<p>Урт хугацааны хандлагатай гэдэг нь</p> <ul style="list-style-type: none"> • тууштай (шаргуу) • хүмүүсийн хоорондын харилцаа статусаас хамааралтай • олон үнэн байх боломж (цаг хугацаа, нөхцөл хамаарч) • зуршил • ичих мэдрэмжтэй байх <p>Богино хугацааны хандлагатай гэдэг нь</p> <ul style="list-style-type: none"> • хувийн тууштай, тогтвортой байдлыг хангах • богино хугацааны чиг баримжаа олгох; Богино мөчлөг санал • уламжлалыг хүндэтгэх • мэндчилгээ, ач тус, бэлэг сэлт харилцан солилцох • туйлын үнэн (жишээ нь таталцлын хуулийг) 																		
3	Шинж тэмдэгүүд	<table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th style="width: 50%; text-align: left;">Өндөр үед</th> <th style="width: 50%; text-align: left;">Бага үед</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Тэсвэр хатуужил, шаргуу байдал</td> <td>Хурдан шаламгай байдалтай</td> </tr> <tr> <td>Аливаа харилцаанд статусын үүрэг рольтой</td> <td>Статусыг хамааруулахгүй байдалтай</td> </tr> <tr> <td>Дасан зохицох байдалтай</td> <td>Гөжүүд, зөрүүд</td> </tr> <tr> <td>Гадаад төрх байдал харах байдал сул</td> <td>Гадаад төрх харах байдалтай</td> </tr> <tr> <td>Хувь хүний цагийн зохион байгуулалт чухал биш</td> <td>Өөртөө зориулж цаг гаргах байдалтай</td> </tr> <tr> <td>Хэмнэлтийн байдалтай Үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх байдалтай</td> <td>Төрөл бүрийн зүйлд хөрөнгө оруулалт хийдэг</td> </tr> <tr> <td>Ажил эрхлэлт, харилцааг зэрэг чухалчилдаг</td> <td>Эцсийн үр дүнг чухалчилдаг</td> </tr> <tr> <td>Карма</td> <td>Сайн муугийн талаарх ялгааны абсалют утгатай</td> </tr> </tbody> </table>	Өндөр үед	Бага үед	Тэсвэр хатуужил, шаргуу байдал	Хурдан шаламгай байдалтай	Аливаа харилцаанд статусын үүрэг рольтой	Статусыг хамааруулахгүй байдалтай	Дасан зохицох байдалтай	Гөжүүд, зөрүүд	Гадаад төрх байдал харах байдал сул	Гадаад төрх харах байдалтай	Хувь хүний цагийн зохион байгуулалт чухал биш	Өөртөө зориулж цаг гаргах байдалтай	Хэмнэлтийн байдалтай Үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх байдалтай	Төрөл бүрийн зүйлд хөрөнгө оруулалт хийдэг	Ажил эрхлэлт, харилцааг зэрэг чухалчилдаг	Эцсийн үр дүнг чухалчилдаг	Карма	Сайн муугийн талаарх ялгааны абсалют утгатай
Өндөр үед	Бага үед																			
Тэсвэр хатуужил, шаргуу байдал	Хурдан шаламгай байдалтай																			
Аливаа харилцаанд статусын үүрэг рольтой	Статусыг хамааруулахгүй байдалтай																			
Дасан зохицох байдалтай	Гөжүүд, зөрүүд																			
Гадаад төрх байдал харах байдал сул	Гадаад төрх харах байдалтай																			
Хувь хүний цагийн зохион байгуулалт чухал биш	Өөртөө зориулж цаг гаргах байдалтай																			
Хэмнэлтийн байдалтай Үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх байдалтай	Төрөл бүрийн зүйлд хөрөнгө оруулалт хийдэг																			
Ажил эрхлэлт, харилцааг зэрэг чухалчилдаг	Эцсийн үр дүнг чухалчилдаг																			
Карма	Сайн муугийн талаарх ялгааны абсалют утгатай																			
4	Асуултууд – VSM2013	<p>LTO = 40(m13 – m14) + 25(m19 – m22) + C(Is)</p> <p>13. Найз нөхөддөө тусалдаг байх Дээд зэргийн чухал (1) = Богино хугацаа</p> <p>14. Арвич хямгач байх - хэрэгцээнээсээ илүүг зарцуулахгүй байх Дээд зэргийн чухал (1) = Урт хугацаа</p> <p>19. Та Монгол улсын иргэн гэдгээрээ бахархдаг уу.</p>																		

Дээд зэргийн чухал (1) = Богино хугацаа
 22. Шаргуу байх нь үр дүнд хүрэх хамгийн зөв арга мөн
 Дээд зэргийн чухал (1) = Урт хугацаа

5 Судалгааны үр дүн - асуулга


Судалгааны үр дүнг 4214 оролцогчийн мэдээлэлд тулгуурлан гаргав.

Урт болон богино хугацааны хандлага




Асуулт 13: Уг асуултын дундаж оноо бага байх тусам богино хугацааны хандлага давамгайлж байгааг харуулах бөгөөд 2,39 гарсан байна.

Найз нөхөддөө тусалдаг байх




Асуулт 14: Уг асуултын дундаж бага байх тусам урт хугацааны хандлага давамгайлж байгаа бөгөөд дундаж 2,38 гарсан байна.

Арвич хямгач байх - хэрэгцээнээсээ илүүг зарцуулахгүй байх




Асуулт 19: Уг асуултын дундаж оноо бага байх тусам богино хугацааны хандлага давамгайлж байгааг харуулах бөгөөд 1,76 гарсан байна.

Та Монгол улсын иргэн гэдгээрээ бахархдаг уу



Асуулт 22: Уг асуултын дундаж бага байх тусам урт хугацааны хандлага давамгайлж байгаа бөгөөд дундаж 1,78 гарсан байна.

Шаргуу байх нь үр дүнд хүрэх хамгийн зөв арга мөн



Дүгнэлт: Урт болон богино хугацааны хандлагыг илэрхийлсэн асуултуудын дундаж нь хоорондоо зөрүү маш багатай байна.

$$LTO = 40(2.39 - 2.38) + 25(1.76 - 1.78) + 32.5 = 32.4$$

6 Судалгааны үр дүн - ярилцлага

Хэл шинжлэлийн ухааны доктор Д.Төмөртоогоо: Монголчууд аливаа зүйлд хурдан дасдаг, тэр чинээгээрээ хурдан хувирдаг. Өөрөөр хэлбэл соёлын дархлаа муутай байна. Энэ байдал нь аливаа гадны соёлын нөлөөнд ороход илүү хурдан байдаг тул соёлын бодлого хүчтэй байхыг шаарддаг. Эс бөгөөс бид гадны соёлыг эсэргүүцэх чадвар муудаж мөхөх шинжтэй болох тул анхаарах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Эдийн засгийн ухааны доктор П.Очирбат:Ер нь, монголчуудад шунал байдаггүй. Шунал хүнийг эвддэг. Хуримтлах, хадгалах, бөөгнүүлэх шуналын сэдэл, баян байх гэсэн сэтгэлгээ, өмчийн сэтгэхүйнээс болж ааш зан эвдэрч байна. Өмчийн сэтгэлгээ нүүдэлчдэд тогтохгүй байх шиг байна. Эд хөрөнгө ба сэтгэл гэсэн хоёр зүйлийн тэнцвэрийг олбол болох юм шиг.


		<p>Удирдахуйн ухааны доктор Я.Бямбасүрэн: Богино хугацаанд хандах хандлага давамгайлж байна. Бизнес богино хугацаанд өндөр ашиг олох соирхол хүмүүст давамгайлж байна. Улс орны хувьд бодлого боловсруулахдаа шинж тэмдэг хараад шийдвэр гаргаж байна. Улс төрийн намын зорилго нь улс орны хөгжлийг түүчээлэн удирдах гэхээс илүүтэйгээр сонгуульд ялахыг гол зорилго болгож байгаад шүүмжлэлтэй ханддаг. Иймээс богино хугацааны хандлага өсч байна.</p> <p>Философийн ухааны доктор Б.Пүрэвсүрэн : Монголчуудын хувьд богино хугацааны хандлага арай давамгайлж байдаг. Аливаа төлөвлөлтийг батлаад маргах тохиолдол түгээмэл байдаг. Ер нь тодорхой зорилгогүй байх хандлага давамгайлж байдаг. Улс орны хувьд 4 жилийн цикл байдаг ч тэр хугацаанд ч бодлого тогтмол байхгүй байна. Түүнчлэн байгууллага уртдаа 1 жил, хувь хүмүүс бараг өдрийн циклтэй баримжаатай байгаа нь түгээмэл байна.</p>
--	--	--

4. ЧӨЛӨӨТ ҮҮ, БАРИГДМАЛ УУ (INDULGENCE VS RESTRAINT)

№	Indulgence vs Restraint- Чөлөөт үү баригдмал уу– хүсэл тэмүүлэл, найз нөхөд, зугаа цэнгэл, секс, хэрэглээ зэрэгт хэт их хандаж байна уу, эсвэл өөрийгөө хязгаарлах, болгоомжтой хандах хандлагатай байна уу?	
1	Судлах үндэслэл	Тухайн улс орны иргэдийн аз жаргалын хүчин зүйлсийг судалснаар тухайн нийгмийн онцлогыг судлаж хэрэглэгчийн үйлчилгээ, хүний нөөцийн бодлого болон бараа бүтээгдэхүүний маркетингийн стратегийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг байна.
2	Онолын хэсэг	<p>Чөлөөт нийгэм хүмүүсийн амьдралдаа сэтгэл хангалуун, зугаа цэнгэлтэй байхыг хүлээн зөвшөөрдөг.</p> <p>Баригдмал нийгэм хүмүүсийн амьдралын баяр баясгалан, зугаа цэнгэлийг нийгмийн хүчтэй хэм хэмжээ, дүрэм журмаар хязгаарлаж байдаг.</p> <p>2010 онд Hofstede-ийн сүүлд нэмсэн ирсэн хэмжүүр бол чөлөөт нийгмийг харьцуулах нь баригдмал нийгэм. Энэ хэмжүүр нэмэгдсэн шалтгаан өмнөх хэмжүүрүүдэд дурьдагдаагүй хүчин зүйл болох аз жаргалд төвлөрсөн байдаг.</p> <p>Зургаа дахь хэмжүүр нь олон улсын сургалт болон менежментийн салбарт төдийлөн их хэрэглээ болоогүй шинэ хэмжүүр юм. Тиймээс үүний судалгаа олон улс цөөхөн хийгдсэн байдаг. Энэ хэмжүүрийг аз жаргалын судалгаанд төвлөрсөн гэж үздэг бөгөөд аз жаргал улс орны соёлын ялгаанаас хамаарч өөр тайлбарлагдана гэжээ. Судалгааны асуултуудаар судалгаанд оролцогчдыг хэр аз жаргалтай байгаагаа илэрхийлснийг өгөгдлийн хүчинтэй байдлаар баталгаажуулдаг байна.</p> <p>Энэхүү хэмжүүрийг олон улсын ажлын байран дээр ашиглах боломжтой сонирхолтой бололцоонууд байсаар байна. Жишээлбэл, чөлөөт соёлд</p>

		<p>хамгийн чухал зүйл бол ярих эрх чөлөө байдаг бол баригдмал соёлд хувь хүний заяа төөргийн тухайд тусламж хэрэгтэй зүйл үздэг байна.</p> <p>Хувь хүний аз жаргал, эрх чөлөөг илүү чухал гэж үздэг соёлд хэрэв ажилтнууд ажилдаа сэтгэл ханамжгүй бол байгууллагыг орхиход бэлэн байдаг байж магадгүй юм.</p> <p>Мөн энэ хэмжүүр сонирхолтой нэг тал бол хэрэглэгчдийн үйлчилгээний хандлагууд байж болох юм.</p> <p>Мөн энэ хэмжүүр нь үе үеийн ялгаанд нөлөөлдөг байж болох юм.</p>																
3	Шинж тэмдэгүүд	<table border="1"> <thead> <tr> <th>Чөлөөт нийгэм</th> <th>Баригдмал нийгэм</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>• Ихэнхи хүмүүс нь үнэхээр аз жаргалтай гэж өөрсдийгөө зарладаг.</td> <td>• Цөөн тооны аз жаргалтай хүмүүстэй</td> </tr> <tr> <td>• Чөлөөт байдал үнэхээр чухал</td> <td>• Чөлөөт байдал тийм ч чухал биш</td> </tr> <tr> <td>• Боловсролтой хүмүүстэй, төрөлт өндөртэй</td> <td>• Боловсролтой хүмүүстэй, төрөлт багатай</td> </tr> <tr> <td>• Спортоор идэвхитэй хичээллэдэг.</td> <td>• Цөөн хүн л спортоор идэвхитэй хичээллэдэг.</td> </tr> <tr> <td>• Таргалалт их</td> <td>• Таргалалт бага</td> </tr> <tr> <td>• Гэмт хэрэг өндөр</td> <td>• Гэмт хэрэг бага</td> </tr> <tr> <td>• Эрх чөлөөг эрхэмлэдэг</td> <td>• Хүчтэй засгийн газрыг эрхэмлэдэг.</td> </tr> </tbody> </table>	Чөлөөт нийгэм	Баригдмал нийгэм	• Ихэнхи хүмүүс нь үнэхээр аз жаргалтай гэж өөрсдийгөө зарладаг.	• Цөөн тооны аз жаргалтай хүмүүстэй	• Чөлөөт байдал үнэхээр чухал	• Чөлөөт байдал тийм ч чухал биш	• Боловсролтой хүмүүстэй, төрөлт өндөртэй	• Боловсролтой хүмүүстэй, төрөлт багатай	• Спортоор идэвхитэй хичээллэдэг.	• Цөөн хүн л спортоор идэвхитэй хичээллэдэг.	• Таргалалт их	• Таргалалт бага	• Гэмт хэрэг өндөр	• Гэмт хэрэг бага	• Эрх чөлөөг эрхэмлэдэг	• Хүчтэй засгийн газрыг эрхэмлэдэг.
		Чөлөөт нийгэм	Баригдмал нийгэм															
		• Ихэнхи хүмүүс нь үнэхээр аз жаргалтай гэж өөрсдийгөө зарладаг.	• Цөөн тооны аз жаргалтай хүмүүстэй															
		• Чөлөөт байдал үнэхээр чухал	• Чөлөөт байдал тийм ч чухал биш															
		• Боловсролтой хүмүүстэй, төрөлт өндөртэй	• Боловсролтой хүмүүстэй, төрөлт багатай															
		• Спортоор идэвхитэй хичээллэдэг.	• Цөөн хүн л спортоор идэвхитэй хичээллэдэг.															
		• Таргалалт их	• Таргалалт бага															
		• Гэмт хэрэг өндөр	• Гэмт хэрэг бага															
• Эрх чөлөөг эрхэмлэдэг	• Хүчтэй засгийн газрыг эрхэмлэдэг.																	
4	Асуултууд – VSM2013	<p>11. Өөртөө хөгжилдөх цаг гаргах</p> <p>12. Тэвчээртэй: Хүсэл зоригоо хязгаарладаг байх</p> <p>16. Та аз жаргалтай хүн үү</p> <p>17. Хэн нэгэн эсвэл тодорхой нөхцөл байдал таныг үнэхээр хүсч байгаа зүйлээс тань татгалзахад хүргэж байсан уу.</p>																
5	Судалгааны үр дүн - асуулга	<p>11. Өөртөө хөгжилдөх цаг гаргах</p> <p>Уг асуултанд нийт 4207 хүн хариулснаас 48 хувь буюу 1930 хүн маш чухал ба дээд зэргийн чухал гэжээ. Бага зэргийн чухал болон чухал биш гэдэгт 707 хүн буюу 16,8 хувь л хаирулт өгчээ. Үүнээс харахад манай улс орны хувьд өөртөө хөгжилдөх, баярлах цаг гарах дуртай хүмүүс байгаа нь чөлөөт нийгмийн шинж тэмдэг “Чөлөөт байдал үнэхээр чухал” илэрч байгааг дээрхи асуулт баталгаажуулж байна.</p> <p>Тус асуултанд дээд зэргийн болон маш чухал гэж хариулса хүмүүс насаар харахад 20-с доош болон 20-24 насны ихэнхидээ байна.</p>																


11. Өөртөө хөгжилдөх цаг гаргах



12. Тэвчээртэй: Хүсэл зоригоо хязгаарладаг байх

Нийт 4203 хүн энэхүү асуултанд хариулснаас хүсэл зоригоо хязгаарладаг байх нь дээд зэргийн чухал гэж 14 хувь, маш чухал гэж 35,6 хувь, нэлээд чухал гэж 35,6 хувь буюу нийт 85,1 хувь байгаа нь баригдмал нийгмийн шинж тэмдгийг харуулж байна.


12. Тэвчээртэй: Хүсэл зоригоо хязгаарладаг байх



16. Та аз жаргалтай хүн үү

Асуултанд нийт 4211 хүн хариулснаас үргэлж аз жаргалтай байдаг гэдэг 24,4 хувь, ихэвчлэн аз жаргалтай байдаг гэж 53,6 хувь байгаа нь нийт асуултанд хариулсны хүний 78 хувь байна. Үүнээс харахад манай нийгэм чөлөөт нийгмийн “Ихэнхи хүмүүс нь үнэхээр аз жаргалтай гэж өөрсдийгөө зарладаг” гэх шинж тэмдэгтэй нийцэж байна.


16. Та аз жаргалтай хүн үү?



17. Хэн нэгэн эсвэл тодорхой нөхцөл байдал таныг үнэхээр хүсч байгаа зүйлээс тань татгалзахад хүргэж байсан уу.

Нийт 4199 хүн уг асуултанд хариулснаас үргэлж гэж 3,7 хувь, ихэвчлэн гэж 17,8 хувь заримдаа гэж 56,8 хувь хариулжээ. Энэ үр дүнгээс харахад хэн нэгэн эсвэл тодорхой нөхцөл байдал хувь хүнийг үнэхээр хүсч байгаа зүйлээс нь татгалзахад заримдаа л хүргэдэг гэж нийт судалгаанд оролцддын талаас илүү хувь хариулсан байгаа нь чөлөөт болон баригдмал нийгмийн шинж тэмдэгтэй бүрэн нийцэхгүй байна.

17. Хэн нэгэн эсвэл тодорхой нөхцөл байдал таныг үнэхээр хүсч байгаа зүйлээс тань татгалзахад хүргэж байсан уу.



Нийт дүгнэлт:

Тус индекс доорх томъёоллоор тооцон гаргана.

$$IVR = 35(m12 - m11) + 40(m17 - m16) + C(ir)$$

Тус асуулт m11 гэдэг нь 11-р асуултын mean үнэлгээг авах гэх мэт.

Тус индекс хэвийндээ 100 хүртэлх тоо байх бөгөөд энэ нь чөлөөт нийгмээс баригдмал нийгмийг тоон үзүүлэлтийн хооронд оршино. C(ir) нь тогтмол хувьсагч бөгөөд тухайн судалгааны өгөгдлөөс хамаардаг бөгөөд

		<p>сөрөг болон эерэг тоо байж болно. Гэхдээ энэ тогтмол тоон улс орнуудыг хооронд нь харьцуулахад нөлөөлөхгүй болно. Тиймээс судлаач өөрийн оноог 0-100 хооронд тоог сонгон авах боломжтой.</p> <p>11. Өөртөө хөгжилдөх цаг гаргах</p> <p>12. Тэвчээртэй:Хүсэл зоригоо хязгаарладаг байх</p> <p>16. Та аз жаргалтай хүн үү</p> <p>17. Хэн нэгэн эсвэл тодорхой нөхцөл байдал таныг үнэхээр хүсч байгаа зүйлээс тань татгалзахад хүргэж байсан уу.</p> <p>IVR = 35(2.53 – 2.55) + 40(2.99 – 2.01) + 37.5= 76</p>
6	Судалгааны үр дүн - ярилцлага	<p>Монголчуудын хувьд илүү чөлөөт талдаа хандлагатай. Монголд болохгүй зүйл гэж байдаггүй. Түүнчлэн Монгол хүмүүсийн хувьд шинэ нөхцөлд хамгийн амархан дасан зохицож адаптацид орж байдаг. Хүчтэй дүрэм журам, шашин сурталтай биш гэж үздэг. Иймээс илүү чөлөөт тал давамгайлдаг.</p>

5. ЭРХ МЭДЛИЙН ЯЛГАА ЗААГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТҮВШИН (POWER DISTANCE INDEX)


№	Монголчуудын эрх мэдлийн ялгаа заагийг хүлээн зөвшөөрөх байдал ямар вэ?	
1	Судлах үндэслэл	<p>Hofstede-ийн судалгаа нь үнэт зүйл тодорхойлох аргазүй дотроос нийгмийн шинжлэх ухааны салбарт хамгийн олон удаа эшлэл хийгдсэн байдаг (Cardon 2008). Академик болон академик бус ажлуудад мөн олон удаа эшлэл авагдсан байдаг (Philler 2011). Үзүүлэлтүүд дундаас эрх мэдлийн ялгаа заагийн үзүүлэлт маш алдартай, судалгаа шинжилгээ шийдвэр гаргалтанд ихээхэн хэрэглэгддэг гэж үздэг (Annelise Ly).</p> <p>PDI –ийн үзүүлэлтийг судлах нь яагаад чухал вэ гэхээр энэ нь гэр бүлийн орчинд, ажил дээр, сургууль дээр, эмнэлэг дээр гэх зэрэг нийгмийн бүхий л хүрээг авч үздэгээрээ онцлог учир нийгмийн үнэт зүйл, соёлыг тодорхойлоход нэн ач холбогдолтой билээ.</p>
2	Онолын хэсэг	<p>PDI-ийн талаарх онолын ойлголтыг Hofstede Cultures Consequences (1980, 2001) бүтээлдээ тодорхой тусгасан байдаг.</p> <p>PDI нь нийгмийн багахан эрх мэдэлтэй гишүүд эрх мэдэл тэнцүү биш хуваарилагдсан гэдэгт итгэдэг болон хүлээн зөвшөөрдөг түвшин юм. Япончууд эрх мэдлийн ялгаа заагийг хүлээн зөвшөөрөх түвшин өндөр гэх мэт. Индекс 0 (зааг ялгаа бага)-ээс 100 (зааг ялгаа их) хүртэл хэмжигдэх бөгөөд 0 ээс бага, 100-аас их байх боломжтой. Энэхүү тодорхойлолт нь Cultures and Organizations бүтээлд (Hofstede et al. 2010:61), мөн http://geert-hofstede.com вебсайт дээр тодорхой тусгасан байдаг.</p> <p>Эрх мэдлийн ялгаа, заагийг хүлээн зөвшөөрөх түвшинг тодорхойлоход гэр бүл, албан байгууллага гээд бүхий л түвшний нийгмийн бүлгийг</p>

		<p>хамааруулж ойлгоно. Эрх мэдлийн ялгаа зааг ихтэй байх нь тухайн нийгмийн хүмүүс иерархийг хүлээн зөвшөөрөх хандлагатай байгааг харуулна. Тухайн нийгэмд амьдарч буй хүмүүст бүгдэд өөр өөрийн гэсэн орон зай байдаг гэж үздэг гэсэн үг юм. Эрх мэдлийг заавал шударгаар, эн тэнцүү түгээнэ гэсэн хувь хүний хэрэгцээ байдаггүй нийгмийн үнэт зүйлтэй гэж үздэг.</p> <p>Харин эрх мэдлийн зааг ялгаа багатай түвшинд эрх мэдлийг тэнцүү хуваарилах үзэл санаан дээр суурьлах ба голцуу зөвшилцөх мэтийн ардчилалын суурь зарчимд тулгуурласан нийгэмд байдаг байна. Энэ нийгэмд хүмүүс эрх мэдлийг тэнцүү хуваарилахыг нийгмээсээ шаарддаг үнэт зүйлийн зарчим үйлчилдэг.</p> <p>Тухайлбал, PDI түвшин өндөр байдаг оронд Латин Америк, Азийн орнууд, Африк болон Арабын зарим газрууд ордог байна. Харин эсрэгээрээ Англо, Германы орнуудад бага түвшинд (Автстри 11, Дани 18) гарсан байна. АНУ-н түвшин 40 байхад, Гуатамала 95, Израйл 13 зэрэг гарсан байна.</p> <p>Европын хойд хэсгийн орнуудын хувьд бага, өмнөд хэсэгт өндөр түвшинд байна. Жишээлбэл, Польш 68, Испани 57, Швед 31, Нэгдсэн Вант улс 35 гэх мэт.</p>																	
3	Шинж тэмдэгүүд	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="475 1081 941 1115">Эрх мэдлийн индекс бага</th> <th data-bbox="941 1081 1426 1115">Эрх мэдлийн индекс өндөр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td colspan="2" data-bbox="475 1115 1426 1149" style="text-align: center;"><i>Улс төрийн системд</i></td> </tr> <tr> <td data-bbox="475 1149 941 1305">Ургалч үзэлтэй засгийн газар олонхийн санал авсан үр дүнд суурилсан байдаг.</td> <td data-bbox="941 1149 1426 1305">Сонгуульд суурилсан зэвсэгт хүчний, дарангуйлалын эсвэл олигарх байдалтай засгийн газартай.</td> </tr> <tr> <td data-bbox="475 1305 941 1462">Улс төрийн намууд зүүн болон барууны үзлийн төвийг сахихыг эрмэлздэг.</td> <td data-bbox="941 1305 1426 1462">Хэрэв улс төрийн намтай бол баруун болон зүүн үзлийн хооронд сул талд туйлшрал бий болсон байдаг.</td> </tr> <tr> <td data-bbox="475 1462 941 1619">Засгийн газар ихэнхдээ нийгмийн ардчилал, эрх тэгш байдлаар онцолсон намуудаар удирдуулдаг.</td> <td data-bbox="941 1462 1426 1619">Хэрэв засгийн газар сонгуулиар гарч ирдэг бол тэд барууны үзлийн намуудаар удирдуулах сонирхолтой байдаг.</td> </tr> <tr> <td data-bbox="475 1619 941 1731">Засгийн газрийн хэлбэр аажмаар өөрчлөгддөг. (хувьсал ба тогтвортой байдал)</td> <td data-bbox="941 1619 1426 1731">Засгийн газрийн хэлбэр гэнэт өөрчлөгддөг. (хувьсал ба тогтворгүй байдал)</td> </tr> <tr> <td data-bbox="475 1731 941 1843">Ихээхэн хэлэлцдэг боловч дотоодын улс төрийн хүчирхийлэл бага.</td> <td data-bbox="941 1731 1426 1843">Бага хэлэлцдэг боловч дотоодын улс төрийн хүчирхийлэл их.</td> </tr> <tr> <td data-bbox="475 1843 941 1955">Иргэд ардчилалыг хэрэгжүүлэх арга замуудад сэтгэл хангалуун байдаг.</td> <td data-bbox="941 1843 1426 1955">Иргэд ардчилалыг хэрэгжүүлэх арга замуудад сэтгэл хангалуун бус байдаг.</td> </tr> </tbody> </table>	Эрх мэдлийн индекс бага	Эрх мэдлийн индекс өндөр	<i>Улс төрийн системд</i>		Ургалч үзэлтэй засгийн газар олонхийн санал авсан үр дүнд суурилсан байдаг.	Сонгуульд суурилсан зэвсэгт хүчний, дарангуйлалын эсвэл олигарх байдалтай засгийн газартай.	Улс төрийн намууд зүүн болон барууны үзлийн төвийг сахихыг эрмэлздэг.	Хэрэв улс төрийн намтай бол баруун болон зүүн үзлийн хооронд сул талд туйлшрал бий болсон байдаг.	Засгийн газар ихэнхдээ нийгмийн ардчилал, эрх тэгш байдлаар онцолсон намуудаар удирдуулдаг.	Хэрэв засгийн газар сонгуулиар гарч ирдэг бол тэд барууны үзлийн намуудаар удирдуулах сонирхолтой байдаг.	Засгийн газрийн хэлбэр аажмаар өөрчлөгддөг. (хувьсал ба тогтвортой байдал)	Засгийн газрийн хэлбэр гэнэт өөрчлөгддөг. (хувьсал ба тогтворгүй байдал)	Ихээхэн хэлэлцдэг боловч дотоодын улс төрийн хүчирхийлэл бага.	Бага хэлэлцдэг боловч дотоодын улс төрийн хүчирхийлэл их.	Иргэд ардчилалыг хэрэгжүүлэх арга замуудад сэтгэл хангалуун байдаг.	Иргэд ардчилалыг хэрэгжүүлэх арга замуудад сэтгэл хангалуун бус байдаг.	
Эрх мэдлийн индекс бага	Эрх мэдлийн индекс өндөр																		
<i>Улс төрийн системд</i>																			
Ургалч үзэлтэй засгийн газар олонхийн санал авсан үр дүнд суурилсан байдаг.	Сонгуульд суурилсан зэвсэгт хүчний, дарангуйлалын эсвэл олигарх байдалтай засгийн газартай.																		
Улс төрийн намууд зүүн болон барууны үзлийн төвийг сахихыг эрмэлздэг.	Хэрэв улс төрийн намтай бол баруун болон зүүн үзлийн хооронд сул талд туйлшрал бий болсон байдаг.																		
Засгийн газар ихэнхдээ нийгмийн ардчилал, эрх тэгш байдлаар онцолсон намуудаар удирдуулдаг.	Хэрэв засгийн газар сонгуулиар гарч ирдэг бол тэд барууны үзлийн намуудаар удирдуулах сонирхолтой байдаг.																		
Засгийн газрийн хэлбэр аажмаар өөрчлөгддөг. (хувьсал ба тогтвортой байдал)	Засгийн газрийн хэлбэр гэнэт өөрчлөгддөг. (хувьсал ба тогтворгүй байдал)																		
Ихээхэн хэлэлцдэг боловч дотоодын улс төрийн хүчирхийлэл бага.	Бага хэлэлцдэг боловч дотоодын улс төрийн хүчирхийлэл их.																		
Иргэд ардчилалыг хэрэгжүүлэх арга замуудад сэтгэл хангалуун байдаг.	Иргэд ардчилалыг хэрэгжүүлэх арга замуудад сэтгэл хангалуун бус байдаг.																		

		Эрх мэдэл, эрх ямба болон эд баялаг бүгд хамтдаа байх хэрэггүй.	Эрх мэдэл нь эрх ямба болон эд баялаг авчирдаг.
		Нийгэм орлогын багахан зөрүүгээр хоорондоо ялгаатай байдаг бөгөөд татварын систем үүнийг багасахад чиглэгддэг.	Нийгэм орлогын их хэмжээгээр зөрүүгээр хоорондоо ялгаатай байдаг бөгөөд татварын систем үүнийг улам нэмэгдүүлдэг.
		Удирдлага хүн амын нийт төлөөллөөс сонгогддог.	Удирдлага нийт хүн амыг төлөөлөл биш байдаг.
		Иргэд сонин, сэтгүүл илүү уншдаг.	Иргэд зурагт илүү үздэг.
		Иргэд хэвлэлд итгэдэггүй боловч цагдан сэргийлэхэд итгэдэг.	Иргэд хэвлэлд итгэдэг боловч цагдан сэргийлэхэд итгэдэггүй.
		Авилга бага: авилгатай холбоотой гэмт хэрэг нь улс төрийн карьерийн төгсгөл болдог.	Авилга их: авилгатай холбоотой гэмт хэргийг нуудаг.
		Чөлөөт үйлдвэрчний эвлэл, прагматик үзэлтэй байдаг.	Хэрэв чөлөөт үйлдвэрчний эвлэлтэй бол улс төр болон үзэл сурталт чиглэсэн байдаг
		Шашин, санаа болон үзэл суртал	
		Эрх тэгш байдлыг шашин болон философийн системээр онцлон тэмдэглэдэг.	Шашин болон философийн системээр үе давхарга, шатлалыг л онцлон тэмдэглэдэг.
		Улс төрийн үзэл суртлыг онцлох болон эрх мэдлийг хуваахад туршлагажсан байдаг.	Улс төрийн үзэл суртлыг онцлох ба эрх мэдлийн тэмцэлд туршлагажсан байдаг.
		Нийгмийн талаарх ургалч үзэлч санаа	Нийгмийн талаарх элит санаа
		Эрх мэдлийн тэг-нийлбэр биш онолууд	Эрх мэдлийн тэг-нийлбэр онолууд
		Хүчний хэрэглээ эрх мэдлийн уналтаар илэрдэг.	Хүчний хэрэглээ эрх мэдлийн гол зүйл нь байдаг.
		Мори, Маркс, Энгель, Вебер, Мулдэр, Лакерт, Миллэр	Мачиавилла, Ла Бозтэ, Хоббис, Моска, Парето, Мишэлс
4	Асуултууд – VSM2013	<p>7. Ажилтай холбоотой шийдвэр гаргалтанд удирдлага тань зөвлөдөг байх</p> <p>2. Хүндэтгэл хүлээж чадахуйц шууд удирдлагатай байх</p> <p>20. Таны туршлагаас харахад хүмүүс удирдлагатайгаа зөрчилдөхөөс хэр их айдаг вэ?</p> <p>23. Ажилтнуудын хувьд 2 даргатай байх байгууллагын бүтцээс ямагт зайлсхийх хэрэгтэй.</p> <p>PDI = 35(2.44 – 2.11) + 25(3.19 – 2.36) + C(pd)=32.3</p>	
5	Судалгааны үр дүн - асуулга	<p>7. Ажилтай холбоотой шийдвэр гаргалтанд удирдлага тань зөвлөдөг байх</p> <p>Уг асуултанд нийт 4209 хүн хариулснаас 54 хувь буюу 2295 хүн маш чухал ба дээд зэргийн чухал гэжээ. Бага зэргийн чухал болон чухал биш гэдэгт 463 хүн буюу 11 хувь л хариулт өгчээ. Үүнээс харахад манай улс</p>	

орны хувьд ажилтай холбоотой шийдвэр гаргалтанд удирдлага тань зөвлөдөг байх нь үнэхээр чухал буюу эрх мэдлийн индекс бага байх шинж тэмдэг илэрч байгааг дээрхи асуулт баталгаажуулж байна.


7. Ажилтай холбоотой шийдвэр гаргалтанд удирдлага тань зөвлөдөг байх



2. Хүндэтгэл хүлээж чадахуйц шууд удирдлагатай байх

Нийт 4243 хүн энэхүү асуултанд хариулснаас хүндэтгэл хүлээж чадахуйц шууд удирдлагатай байх нь дээд зэргийн чухал гэж 24 хувь, маш чухал гэж 49 хувь, нэлээд чухал гэж 22 хувь буюу нийт 94 хувь байгаа нь эрх мэдлийн индекс өндөр байх шинж тэмдгийг харуулж байна.

2. Хүндэтгэл хүлээж чадахуйц шууд удирдлагатай байх




20. Таны туршлагаас харахад хүмүүс удирдлагатайгаа зөрчилдөхөөс хэр их айдаг вэ?

Асуултанд нийт 4202 хүн хариулснаас өөрийн туршлагаар хүмүүс удирдлагатай зөрчилдөхөөс хэзээ ч айдаггүй гэдэг 7 хувь, хаяа айдаг гэж 25 хувь байгаа нь нийт асуултанд хариулсны хүний 32 хувь байна. Харин ихэвчлэн айдаг гэдэгт 37 хувь, заримдаа айдаг гэж 20 хувь тус тус

хариулжээ. Үүнээс харахад эрх мэдлийн индекс өндөр байх шинж тэмдэгтэй нийцэж байна.


20. Таны туршлагаас харахад хүмүүс удирдлагатайгаа зөрчилдөхөөс хэр их айдаг вэ?



23. Ажилтнуудын хувьд 2 даргатай байх байгууллагын бүтцээс ямагт зайлсхийх хэрэгтэй.

Нийт 4207 хүн уг асуултанд хариулснаас үнэхээр санал нийлдэг гэж 19 хувь, санал нийлдэг гэж 42 хувь, одоогоор шийдээгүй гэж 26 хувь хариулжээ. Энэ үр дүнгээс харахад ажилтнуудын хувьд 2 даргатай байх байгууллагын бүтцээс ямагт зайлсхийх хэрэгтэй гэдэгтэй 61 хувь санал нийлж байгаа нь эрх мэдлийн индексийг бага байлгах хандлагатай байна.

23. Ажилтнуудын хувьд 2 даргатай байх байгууллагын бүтцээс ямагт зайлсхийх хэрэгтэй.



Нийт дүгнэлт:

Тус индекс доорх томъёоллоор тооцон гаргана.

		$PDI = 35(m07 - m02) + 25(m20 - m23) + C(pd)$ <p>Тус асуулт m7 гэдэг нь 7-р асуултын mean үнэлгээг авах гэх мэт.</p> <p>Тус индекс хэвийндээ 100 хүртэлх тоо байх бөгөөд энэ нь чөлөөт нийгмээс баригдмал нийгмийг тоон үзүүлэлтийн хооронд оршино. C(pd) нь тогтмол хувьсагч бөгөөд тухайн судалгааны өгөгдлөөс хамаардаг бөгөөд сөрөг болон эерэг тоо байж болно. Гэхдээ энэ тогтмол тоон улс орнуудыг хооронд нь харьцуулахад нөлөөлөхгүй болно. Тиймээс судлаач өөрийн оноог 0-100 хооронд тоог сонгон авах боломжтой.</p>
6	Судалгааны үр дүн - ярилцлага	<p>Хэл шинжлэлийн ухааны доктор Д.Төмөртоогоо: Яг өнөөдрийн хандлагаар эрх мэдлийн зааг ялгаа маш бага байна. Удирдаж буй хүмүүсээ ялгавартай авч үзэхээс илүү тэдэнтэй барьцсан шинжтэй харилцдаг. Уламжлалаасаа хэт холдож, нийгмийн сэтгэлгээ ихээр бохирдож байна.</p> <p>Эдийн засгийн ухааны доктор П.Очирбат: Монголчууд ер нь түүх, хаан 2-т л захирагдаж байсан ард түмэн. Одоо бол Ардчилал хэмээн ард түмний засаглалтай болохоор нийгмээрээ жаахан зүг чигээ алдаад байгаа мэт сэтгэгдэл төрдөг.</p> <p>Удирдахуйн ухааны доктор Я.Бямбасүрэн: Ерөнхийдөө субъектив хүчин зүйлээр эрх мэдлийн ялгаа заагийг үүсгэж байдаг. Социализмын үед хэн ч хаана ч байсан амжилтанд хүрч болно гэсэн итгэлийг нийгэмд төрүүлэх гэж хичээсэн. Өрөөр хэлбэл тэнцүү хуваарилах гэж оролдсон гэсэн үг. Одоо цагт нам эвсэлтэй холбоотойгоор зааг ялгаа үүсгэж буй гэж ойлгож байна. Ерөнхийдөө өмчтэй холбоотойгоор зааг ялгаа мөн үүсч байгаа ч хэн яаж өмчтэй болсонд сэжигтэй ханддаг. Багш оюутны хувьд өндөр биш, удирдлага ажилтаны хувьд албан тушаалтай холбоотойгоор үүсч байгаа ч үнэндээ итгэл хүндлэл дээр суурьлахгүй байгаа.</p> <p>Философийн ухааны доктор Б.Пүрэвсүрэн : Монголчуудын хандлага бол Ази биш, Европ ч биш. Минийхээр бол PDI түвшин бага байх гэж бодож байна. Социализмын үед албадлагаар бууруулах гэж оролдсон. Удирдлагын талаас хий гэж захиран тушаахаас илүүтэйгээр хийцгээе хэмээн манлайлах нь одоо чухал гэж бодож байна. Ажлын хувьд ч найзан дундаа байх хандлага илүүтэй байдаг. Ерөнхийдөө засаглалын талаарх ойлголт султайгаас үүдэн асуудал ихээр үүсч байна. Дээр нь Монголчууд “Би” гэсэн үзэл өндөртэй, хүн ам цөөтэй тул хүн бүр өөрсдийгөө баатар гэж үздэг. Тиймээс гадаадад очоод олон хүний нэг юм байна гэж өөрийгөө хэт дээгүүр үнэлэх үнэлэмж буурдаг байх.</p>

6. ТОДОРХОЙГҮЙ БАЙДЛААС ЗАЙЛСХИЙХ БОЛОН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТҮВШИН (UNCERTAINLY AVOIDANCE INDEX)

№	Монголчууд урт хугацаанд ханддаг уу, богино хугацааны хандлагатай юу? Өнөөдрөөрөө амьдарч байна уу, ирээдүйд хандсан хандлага их байна уу?	
1	Судлах үндэслэл	<p>Хүмүүс тодорхойгүй болон эргэлзээтэй байдлын аюулыг мэдэрч буй болон энэ нөхцөл байдлыг эсэргүүцэж буй түвшин</p> <p>Зарим хүмүүс эргэлзээтэй, тодорхойгүй байдлыг нэг их тоодоггүй байхад зарим нь ийм байдлыг үзэн ядаж үүнийг даван дийлэхийн тулд дүрэм бий болгож үйл хөдлөлийг зааварчлах гэдэг. Энэ хэмжүүрээр хэмжихдээ тодорхойгүй байдлаас зугтах түвшин өндөр, түвшин бага гэж ангилна. /100 баллаар дүгнэнэ(0- тодорхойгүй байдлыг эсэргүүцэх түвшин сул)</p>
2	Онолын хэсэг	<p>Тодорхойгүй байдлаас зайлсхийх гэдэг нь тодорхой бус эсвэл эргэлзээтэй байдал дах нийгмийн хүлээлттэй холбоотой юм. Энэ нь эмх замбраагүй нөхцөл байдалд тохиромжтой эсвэл тохиромжгүй байдлын аль нэгээр соёлын хөтөлбөрөөр гишүүдээ тэлэх байдлыг харуулдаг. Эмх замбраагүй байдал гэдэг нь мэдэхгүй, гэнэтийн, ердийн байдлаас ялгаатай байдал. Тодорхой бус байдлаас зайлсхийх соёл нь хатуу хууль, дүрэм журам, аюулгүй ажиллагааны арга хэмжээгээр тухайн нөхцөл байдлыг боломжийг багасгахыг оролддог. Тодорхой бус байдлаас зайлсхийх улс орны хүмүүс илүү сэтгэл хөдлөлтэй, идэвхтэй байдаг. Эерэг төрлийн, тодорхой бус байдлыг хүлээн зөвшөөрөх соёл нь тэд юу хэрэглэсэн бэ гэдгээс ялгаатай дүгнэлтийг илүү хүлээцтэй байдаг, тэд аль болох цөөн тооны дүрэм журамтай байхыг эрмэлзэх, ба гүн ухааны болон шашны түвшинд тэд реалистик бөгөөд олон урсгалаар тал тал тийш урсахыг хүлээн зөвшөөрдөг. Ийм соёл дотор хүмүүс илүү фелегматик, аливааг тунгаан боддог, харин сэтгэл хөдлөлөө илэрхийлэхдээ өөрийн орчноор таамагладаггүй.</p>
3	Шинж тэмдэгүүд	Доорх хүснэгтэнд харуулав.
4	Асуултууд – VSM2013	<p>$UAI = 40(m18 - m15) + 25(m21 - m24) + C(ua)$</p> <p>15. Та хэр их бухимдаж цухалддаг вэ?</p> <p>Үргэлж (1) = Зайлсхийх түвшин их</p> <p>18. Ойрын өдрүүдэд таны эрүүл мэндийн байдал ерөнхийдөө ямар байна вэ?</p> <p>Маш сайн (1) = Зайлсхийх түвшин бага</p> <p>21. Ажилтныхаа тавьсан ажилтай холбоотой асуулт бүрт оновчтой сайн хариулт өгөөд байдаггүй ч сайн менежер байж болно.</p> <p>Үнэхээр санал нийлж байна (1) = Зайлсхийх түвшин бага</p>

24. Аливаа байгууллагын дүрэм журам нь ямар ч тохиолдолд зөрчигдөх ёсгүй. Энэ дүрэм журмыг зөрчсөнөөр байгууллагад ашигтай байх тохиолдолд ч гэсэн.

Үнэхээр санал нийлж байна (1) = Зайлсхийх түвшин их


5 Судалгааны үр дүн - асуулга

Судалгааны үр дүнг 4214 оролцогчийн мэдээлэлд тулгуурлан гаргав.

Асуулт 18:

Ойрын өдрүүдэд таны эрүүл мэндийн байдал ерөнхийдөө ямар байна вэ?		
Хариулт	Давтамж	Хувь
Маш сайн	584	14%
Сайн	2140	51%
Яахав дээ	1226	29%
Муу	233	6%
Маш муу	29	1%
Mean	2.28	
Mode	2	


Ойрын өдрүүдэд таны эрүүл мэндийн байдал ерөнхийдөө ямар байна вэ?



Асуулт 15:

Та хэр их бухимдаж цухалддаг вэ?		
Хариулт	Давтамж	Хувь
Үргэлж	125	3%
Ихэвчлэн	681	17%
Заримдаа	1898	47%
Хааяа	1265	31%
Хэзээ ч үгүй	67	2%
Mean	3.12	
Mode	3	

Та хэр их бухимдаж цухалддаг вэ?




Асуулт 21:

Ажилтныхаа тавьсан ажилтай холбоотой асуулт бүрт оновчтой сайн хариулт өгөөд байдаггүй ч сайн менежер байж болно.

Хариулт	Давтамж	Хувь
Үнэхээр санал нийлж байна	375	9%
Санал нийлж байна	2207	52%
Одоогоор шийдээгүй байна	711	17%
Санал нийлэхгүй байна	806	19%
Огт санал нийлэхгүй байна	105	2%
Mean	2.54	
Mode	2	

Ажилтныхаа тавьсан ажилтай холбоотой асуулт бүрт оновчтой сайн хариулт өгөөд байдаггүй ч сайн менежер байж болно.



Асуулт 24:

<p>Аливаа байгууллагын дүрэм журам нь ямар ч тохиолдолд зөрчигдөх ёсгүй. Энэ дүрэм журмыг зөрчсөнөөр байгууллагад ашигтай байх тохиолдолд ч гэсэн.</p>		
Хариулт	Давтамж	Хувь
Үнэхээр санал нийлж байна	651	15%
Санал нийлж байна	1831	44%
Одоогоор шийдээгүй байна	888	21%
Санал нийлэхгүй байна	732	17%
Огт санал нийлэхгүй байна	99	2%
Mean	2.48	
Mode	2	

Аливаа байгууллагын дүрэм журам нь ямар ч тохиолдолд зөрчигдөх ёсгүй. Энэ дүрэм журмыг зөрчсөнөөр байгууллагад ашигтай байх тохиолдолд ч гэсэн.

Хариулт	Хувь
Үнэхээр санал нийлж байна	15%
Санал нийлж байна	44%
Одоогоор шийдээгүй байна	21%
Санал нийлэхгүй байна	17%
Огт санал нийлэхгүй байна	2%

Дүгнэлт: Тодорхойгүй байдлаас зайлсхийх түвшин бага гарсан.

UAI = 40(2.28 – 3.12) + 25(2.54 – 2.48) + 32.5 = 0.4

| 6 | Судалгааны үр дүн - ярилцлага | Тодорхой байх хэцүү, зорилго богино хугацаатай тул тодорхой байлгах боломж багатай. Үргэлж тодорхойгүй нөхцөлд шийдвэр гаргаж байна. Тодорхой нөхцөл бий болгох боломжтой. Гэхдээ маш сайн хуулиа дагадаг болох нь чухал. Үндсэн хуулийн цэц, шүүхийн шийдвэрийг шүүгчдийн 60 хувь эсэргүүцэж байгаа нөхцөлд тодорхой байх боломжгүй. |

Тодорхойгүй байдлаас зугтах индекс багатай болон ихтэй нийгмийн гол ялгаатай талууд: Хэрэглэгчийн зан төлөв, Хууль тогтоомж, Онол, Тоглоом, Улс төр төр

Тодорхойгүй байдлаас зугтах индекс бага	Тодорхойгүй байдлаас зугтах индекс өндөр
<i>Хэрэглээний зан төлөв</i>	

Тохиромжтой бүтээгдэхүүний хэрэглээ	Цэвэр байгалийн гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ
Ном, сонин сэтгүүл уншдаг	Ном, сонин сэтгүүл бага уншдаг
Интернэт, тест мессежийг хэрэглэдэг.	Интернэт, тест мессежийг хэрэглээ бага
Хуучин машин худалдан авдаг	Шинэ машин худалдан авдаг
Гэртээ бүхнийг өөрөө хийдэг	Тусгай мэргэжилтнүүдийг гэртээ авчирдаг.
Хувьцаагаар хөрөнгө оруулалт хийдэг.	Металл болон үнэт эдлэлд хөрөнгө оруулалт хийдэг.
Төлбөр төлөх хугацаа богино хугацааны мөчлөгтэй	Төлбөр төлөх хугацаа урт хугацааны мөчлөгтэй
<i>Улс төрийн системд</i>	
Иргэд эрх мэдлийг баталгаажуулахын төлөө байдаг	Иргэд эрх мэдлийг баталгаажуулах төлөө байддаггүй.
Иргэд олон нийтийн үйлчилгээнд таатай ханддаг.	Иргэд олон нийтийн үйлчилгээнд тэр бүр таатай ханддаггүй.
Сайн дурын үйл ажиллагаа, нийгэмлэгүүдийн оролцоо өндөр	Сайн дурын үйл ажиллагаа, нийгэмлэгүүдийн оролцоо бага
Улс төрийн ашиг сонирхол өндөр	Улс төрийн ашиг сонирхол бага
Хуучин ардчилал	Шинэ ардчилал
Иргэд засгийн газрын шийдвэрийг эсэргүүцлээ илэрхийлдэг	Иргэдийн эсэргүүцлийг дарах хандлагатай.
Дэд бүтцийн шийдвэр удаан	Дэд бүтцийн шийдвэр хурдан
Улс төрд иргэдийн хандлага эерэг	Иргэд улс төрд дургүй
Иргэдийн үйлчилгээний эрх зүйн цөөн тооны төгсөгчидтэй	Иргэдийн үйлчилгээний эрх зүйн маш олон тооны төгсөгчидтэй
Түлхүүр албан тушаал дэмжих албан тушаалтнууд: Сувилагчийн тоо, эмчийн тооны харьцаа өндөр	Түлхүүр албан тушаал мэргэшсэн албан тушаалтнууд: Сувилагчийн тоо, эмчийн тооны харьцаа бага
Баялаг ихтэй улс оронд авилгал багатай	Баялаг ихтэй улс оронд авилгал ихтэй
Баялаг ихтэй улс оронд засгийн газрын хөндлөнгийн оролцоо эдийн засагт бага	Баялаг ихтэй улс оронд засгийн газрын хөндлөнгийн оролцоо эдийн засагт өндөр
<i>Хууль, эрх зүйд</i>	
Цөөн тооны болон ерөнхий хууль, тогтоомжтой.	Олон тооны болон нарийвчилсан хууль, тогтоомжтой.

Иргэд хууль, эрх зүйн системд эерэг хандлагатай.	Иргэд хууль, эрх зүйн системд сөрөг хандлагатай.
Хууль үргэлж миний талд байдаг.	Хууль үргэлж миний эсрэг байдаг.
Хууль, эрх зүйн дүрмийг гол болгох шаардлагатай	Хэрвээ тодорхой биш бол хуулийг зөрчиж болно.
Баруун жигүүрийн улс төрийн хандлага сул	Баруун жигүүрийн улс төрийн хандлага хүчтэй
Өөрийн эх орноороо бахархдаг. Түүнийхээ төлөө дайтахад бэлэн.	Өөрийн эх орноороо бахархдаггүй.
Арьс өнгөөр ялгаварладаггүй	Арьс өнгөөр ялгаварладаг.
Цагаачлалыг хүлээн авдаг.	Цагаачлалыг хүлээн зөвшөөрдөггүй.
Иргэд энх тайвны төлөө тэмцэж чаддаг	Иргэд энх тайвны төлөө тэмцэж чаддаггүй.

ХАВСРАЛТУУД

1. Судалгааны асуулга
2. Судалгааны асуулт бүрээр гол хандлагыг тодорхойлох шинжилгээ
3. Өдрийн сонинд өгсөн нийтлэл
4. Free will Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын фото тайлан, илтгэлийн материал
5. Хамтач уу бодгальч уу – Экспертүүдийн хэлэлцүүлгийн фото тайлан
6. Оюутны клубын хамтын ажиллагааны тайлан, хэлэлцүүлгийн фото тайлан
7. Түүхэн баримт бичгүүдэд хийсэн судалгаа

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Chinese Culture Connection (a team of 24 researchers, 1987) “Chinese values and the search for culture-free dimensions of culture”. *Journal of Cross-Cultural Psychology*, Vol. 18 no. 2, 143-164.

Hofstede, Geert (1980) *Culture's Consequences: International Differences in Work-Related Values*. Beverly Hills CA: Sage Publications.

Hofstede, Geert (1991) *Cultures and Organizations: Software of the Mind*. New York: McGraw Hill.

Hofstede, Geert (2001) *Culture's Consequences, (Second Edition): Comparing Values, Behaviors, Institutions and Organizations Across Nations*. Thousand Oaks CA: Sage Publications.

Hofstede, Geert and Michael Harris Bond (1988) “The Confucius connection: From cultural roots to economic growth”. *Organizational Dynamics*, Vol. 16 no. 4, 4-21.

Hofstede, Geert and Robert R. McCrae (2004) “Personality and culture revisited: Linking traits and dimensions of culture”. *Cross-Cultural Research*, Vol. 38 no. 1, 52-88.

Hofstede, Geert and Gert Jan Hofstede (2005) *Cultures and Organizations: Software of the Mind. Revised and Expanded 2nd Edition*. New York: McGraw Hill.

Hofstede, Geert, Gert Jan Hofstede and Michael Minkov (2010) *Cultures and Organizations: Software of the Mind. Revised and Expanded Third Edition*. New York: McGraw Hill.

Hofstede, Geert, Bram Neuijen, Denise Daval Ohayv and Geert Sanders (1990) “Measuring organizational cultures: A qualitative and quantitative study across twenty cases”. *Administrative Science Quarterly*, Vol. 35, 286-316.

Hofstede, Geert, Adriana V. Garibaldi de Hilal, Sigmar Malvezzi, Betania Tanure and Henk Vinken (2010) “Comparing regional cultures within a country: Lessons from Brazil”. *Journal of Cross-Cultural Psychology*, Vol. 41 no. 3, 336-352.

Hoppe, Michael H. (1990) *A Comparative Study of Country Elites: International Differences in Work-related Values and Learning and their Implications for Management Training and Development*. Ph.D. thesis University of North Carolina at Chapel Hill.

- Inglehart, Ronald, Miguel Basañez and Alejandro Moreno (1998) *Human Values and Beliefs: A Cross-Cultural Sourcebook. Findings from the 1990-1993 World Values Survey*. Ann Arbor: University of Michigan Press.
- Inglehart, Ronald, Miguel Basañez, Jaime Díez-Medrano, Loek Halman and Ruud Luijkx (2004) *Human Beliefs and Values: A Cross-Cultural Sourcebook Based on the 1999-2002 Values Surveys*. Mexico: Siglo XXI Editores
- Inglehart, Ronald and associates (2007 and ongoing) *World Values Survey: The World's Most Comprehensive Investigation of Political and Sociocultural Change*.
<http://www.worldvaluessurvey.org>
- Klein, Katherine J., Fred Dansereau and Rosalie J. Hall (2004) "Level issues in theory development, data collection, and analysis." *Academy of Management Review*, Vol.19, 195-229.
- Minkov, Michael (2007) *What Makes Us Different and Similar: A New Interpretation of the World Values Survey and Other Cross-Cultural Data*. Sofia, Bulgaria: Klasika I Stil.
- Minkov, Michael (2011) *Cultural Differences in a Globalizing World*. Bingley, UK: Emerald.
- Minkov, Michael (2013) *Cross-Cultural Analysis: The Science and Art of Comparing the World's Modern Societies and Their Cultures*. Sage Publications.
- Minkov, Michael and Hofstede, Geert (2010) "Long- versus short-term orientation: new perspectives". *Asia Pacific Business Review*, Vol. 16 no. 4, 493-504.
- Minkov, Michael and Hofstede, Geert (2011) "The evolution of Hofstede's doctrine". *Cross Cultural Management: An International Journal*, Vol. 18 no. 1, 10-20.
- Minkov, Michael and Hofstede, Geert (2012) "Hofstede's fifth dimension: New evidence from the World Values Survey". *Journal of Cross-Cultural Psychology*, Vol. 43 no. 1, 3-14.
- Van Vugt, Ronnie G.M.A. (2006) *Culture's Consequences Re-examined*. Unpublished Master's Thesis, Radboud Universiteit Nijmegen.
- Сумъяа, Б. (2001). *Монголын нүүдэлчдийн соёл: Орших эс орших*. Улаанбаатар, Монгол.
- ШУА-ийн ФСЭХ. (2013). *Монголын нийгмийн өөрчлөлт. (Нэмж засварласан 2 дахь хэвлэл)* Улаанбаатар, Монгол.
- Булган, Ц. Shalom Schwartz-ийн үнэт зүйлийн судалгааны аргаар Монголчуудын үнэт зүйлийг тодорхойлох нь, Мастерийн судалгааны ажил, 2012 он
- Түвшинзаяа, С. Үндэсний соёлын хэмжүүрүүд ба менежмент, маркетингийн ялгаатай байдал, СЭЗДС, *Монголын эдийн засаг – Өчигдөр, өнөөдөр, маргааш, 2009*, Улаанбаатар, Монгол улс
- S.Tuvshinzaya, G.Narantungalag. *Cultural Dimensions-Mongolia and Chin . Marketing communication and competition*. Professional Publishing, 2007. Praha. ISBN.978-80-7318-634-0